



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НЭЗХЭ-ИЙН

ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАН-2024

MONGOLIA
· ALWAYS · MOVING ·

ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 370 дугаар тогтоол /Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай/-ыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Аялал Жуулчлалын Мэргэжлийн НЭЗХЭ-ийн ерөнхийлөгчийн 2023 оны 11 дүгээр сарын 27- ны өдрийн 23/271 дугаар гэрээ /Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай/ байгуулагдан, АЖМХ анхны ажлуудаа гүйцэтгэж эхэлсэн. Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарь шинэчлэн батлах, эрх шилжүүлэх тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал нь 2024 онд дөрвөн удаа /А/73, А/174, А/239, А/449/ шинэчлэгдэн батлагдсан бөгөөд сүүлийн тушаалаар АЖМХ нь 9 зорилтын хүрээний 35-40 төрлийн арга хэмжээг хариуцан гүйцэтгэх төлөвлөгөөтэй ажилласан. Дээрх төлөвлөгөөт ажлуудаас АЖМХ БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, гэрээтэйгээр 25-30 төрлийн арга хэмжээний гүйцэтгэгчээр ажиллаад байна.

НЭГ. GO MONGOLIA РӨҮДШОУ & ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.44-д "Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ."; 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол; Түлхүүр үг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 433 дугаар тогтоолын 1-д "Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд "Go Mongolia" түлхүүр үгийг, түүнийг дагалдах "Always. Moving" үгийг хэрэглэхээр тогтсугай."; 3-д "Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж, олон улсад таниулах ажлыг зохион байгуулах"; 5-д "Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагад үүрэг болгосугай."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.5.2-д "Монгол Улсыг гадаад орнуудад сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу Зохион байгуулах"; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.2-д "зорилтот зах зээлийн орнуудын онцлогт тохирсон маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлэх", 4.3.6-д "олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх" зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд Go Mongolia рөүд шоууг Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Тайландын Хаант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Бээжин, Шанхай, Хонгконг)-д тус тус зохион байгуулсан. Олон улсын аялал жуулчлалын салбарын үзэсгэлэнд оролцож, Монгол Улсаа сурталчлах ажлын хүрээнд Оросын Холбооны Улсын Эрхүү хотод зохион байгуулагдсан Байкальск олон улсын экспо, Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан Травел экспо, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод зохион байгуулагдсан ITB Berlin-2024 үзэсгэлэн болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод Зохион байгуулагдсан Сөүлийн олон улсын аялал жуулчлалын SITF-2024 үзэсгэлэнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран оролцсон.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭВЕНТ, АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 4.1.2-д "Аялал жуулчлалыг дэмжсэн зөөлөн дэд бүтцийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ."; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.3-д "үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ."; Мазаалай баавгайг үндэсний бахархалт амьтнаар зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 437 дугаар тогтоолын 1- д "2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Мазаалай баавгайг үндэсний бахархалт амьтан"-аар зарласугай.", 2-д "Мазаалай баавгайг үндэсний болон олон улсын хэмжээнд таниулах хүрээнд холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг..." зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр. бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд:

- Со Mongolia үндэсний брэндийг аялал жуулчлалын салбарт танилцуулах үйл ажиллагаа;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх, дотоодын хөрөнгө оруулагчдад аялал жуулчлалын бизнес эрхлэх таатай нөхцөлийг танилцуулах зорилготой "Аялал жуулчлал-Ногоон хөрөнгө оруулалт" чуулган,
- "Аялал жуулчлалын долоо хоног 2024 /Tourism Week 2024/ арга хэмжээ;
- Аялал жуулчлалын олон улсын хөрөнгө оруулалтын чуулган;
- "Мазаалай" олон улсын цас мөсний наадам. Геннисийн рекорд тогтоолгох үйл ажиллагаа;
- Жуулчны баазуудад үзүүлэх шөнийн цахилгааны
- Өвлийн улиралд ажилладаг хөнгөлөлт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

ГУРАВ. ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ ХАМТРАН БАЙГУУЛСАН ЭВЕНТ, АРГА ХЭМЖЭЭ, ХӨТӨЛБӨРҮҮД

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.3-д "үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.", 8.2-д "Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ."; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5-д "Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.7-д "аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх"; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.4-д "аялал жуулчлалын сурталчилгааны дурс бичлэг, зурган контент, гадаад сурталчилгааны хэвлэмэл материалыг боловсруулж түгээх ажлыг зохион байгуулах", 4.3.7-д "олон улсын нэр хүндтэй, олон үзэгчтэй хэвлэл мэдээллийн агентлагуудаар Монгол Улсын сурталчилгаа нэвтрүүлэх", 4.3.8-д "олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх", 4.4.9-д "аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, цар хүрээг өргөжүүлэх", 4.4.13- д "аялал жуулчлалын идэвх багатай 9-5 дугаар сард зохион байгуулагдаж байгаа аялал жуулчлалын арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, байгуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх", 4.4.14-д "шашин, соёл, спорт, адал явдалт аялал, техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтийг агуулсан улирлын хамаарал багатай аялал жуулчлалын төрөл хэлбэрийг бодлогоор дэмжих", 4.4.17-д "нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх":

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 458 дугаар тогтоол зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд:

- АРА өвлийн фестиваль;
- "Хөх сувд" цас мөсний баяр; Месний загасчлалын ДАШТ;
- Түмэн тэмээний баяр;
- Далины баяр;
- Нас Саммит;
- "Гранд тур" олимпиад;
- "Улаанбаатар травел экспо" үзэсгэлэн; Хорека форум;
- "Нэг жуулчин-Нэг хонь", "Хөх баавгай хөтөлбөр";
- "Нас дейли" баг контент хийх аялал;
- Олон улсын инфлюенсерүүдийн аялал зэрэг эвент, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан.

ДӨРӨВ. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХ

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.45-д "Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ."; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.4-д "аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ."; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-д "Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар. стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.5-л "зочид буудал, жуулчны бааз. үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох стандартыг Олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох" зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран дараах журмын шинэ төслийг тус тус боловсруулсан.Үүнд:

- Аялал жуулчлалын цогцолбор.
- Зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох журам;
- Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт;
- Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандарт;
- Зочны гэрийн үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт.
- Одоо хүчинтэй мөрдөгдөж буй дараах стандартуудыг шинэчлэн батлуулахаар төслүүдийг бэлтгэж байна. Үүнд:
- Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага /MNS 6043-2019/;
- Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага /MNS 5927- 2008/;
- Зочид буудалд тавих ерөнхий шаардлага /MNS 4588:2008/;
- Дэн буудлын ерөнхий шаардлага /MNS 5738:2007/
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-наас томилсон ажлын хэсгийн
- боловсруулж, батлуулсан дараах журмын төслүүдийн хэлэлцүүлэгт оролцож, саналууд өгсөн. Үүнд:

Хил орчмын нутаг дэвсгэрийн жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам; Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам; Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам; Өндөр уулын бүсэд авиралт хийх журам.

САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.4.2-д "хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах", 4.4.3-д "аялал жуулчлалын салбарын хөтөч-тайлбарлагч болон зочлох үйлчилгээний сургагч багш, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хамруулах" зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн аялал жуулчлалын газар, Эксперт Хоспиталити ХХК-тай хамтран зочлох үйлчилгээний салбарын хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Сэжун их сургуулийн профессор Kyu Sun Kang, профессор Lee Mi Young нарыг урин, аялал жуулчлалын салбарын 25 байгууллагын 140 орчим удирдах болон үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Аялал жуулчлалын мэргэжлийн хөтөлбөрүүдээр сургалт явуулдаг их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний ажлыг дэмжин урамшуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, бүх нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой "Гранд тур" олимпиадыг "Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг" ТББ-тай хамтран зохион байгуулсан. АЖМХ нь байгууллагын албан ёсны фейсбүүкийн пейжээрээ дамжуулан аялал жуулчлалын салбарын мэдээ, мэдээлэл, бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдэд мэдлэг олгох зорилготой контентуудыг тогтмол бэлтгэн олон нийтэд түгээж байна.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 3.5-д "Зүүн бүсийн хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн "Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс" болно."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.3-д "соёлын өв, түүх, соёлын дурсгалт газарт суурилсан соёлын аялал жуулчлалын шинэ үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх" зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах ажлын хүрээнд Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран дараах тогтоол, шийдвэр гаргах үндэслэл, төслийг боловсруулсан. Үүнд:

- Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 458 дугаар тогтоол;
- 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоол;
- Зүүн бүсийг "Түүхэн аялал жуулчлалын бүс" болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тогтоол;
- Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 239 дүгээр тогтоол;
- Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 189 дүгээр тогтоол;
- Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх арга хэмжээний тухай Үндэсний хорооны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 24/03 дугаар тогтоол.

ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах төрийн болон олон нийтийн байгууллагатай хамтын ажиллагааны санаж бичиг байгуулсан. Үүнд:

- Зам тээврийн яам
- Авто-тээврийн үндэсний төв
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци



MONGOLIA

· ALWAYS · MOVING ·




Стратеги төлөвлөгөөний зорилго 1

ЗОРИЛТ 1

Монгол Улсын гадаад сурталчилгааг өргөжүүлэн, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.44-д “Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.”; 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол; Түлхүүр үг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 433 дугаар тогтоолын 1-д “Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд "Go Mongolia" түлхүүр үгийг, түүнийг дагалдах "Always. Moving" үгийг хэрэглэхээр тогтсугай.”, 3-д “Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж, олон улсад таниулах ажлыг зохион байгуулах”, 5-д “Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагад үүрэг болгосугай.”; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.5.2-д “Монгол Улсыг гадаад орнуудад сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах”; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.2-д “зорилтот зах зээлийн орнуудын онцлогт тохирсон маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлэх”, 4.3.6-д “олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” гэж заасныг тус тус үндэслэв.





Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулсан “Go Mongolia” рөүдшоу

Монгол Улсыг БНСУ-д сурталчлах “Go Mongolia” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар **БОАЖЯ, АЖМХ**, дэмжин ажиллагчаар БНСУ-д улсад суугаа Элчин сайдын яам, ерөнхий гүйцэтгэгчээр АЖМХ, Монгол Улсад бэлтгэл ажлыг хангах туслан гүйцэтгэгчээр “Отек менежмент” ХХК, “Оргил медиа менежмент” ХХК, “Босс техноложи” ХХК болон “Оргил од дизайн” ХХК ажилласан. “Отек менежмент” ХХК нь дуучин, хөтлөгч, бүжиг, балет, дижи тоглолт зэрэг үзүүлбэр үзүүлэх ажлуудыг; “Оргил медиа менежмент” ХХК нь арга хэмжээний хөтөлбөрийг найруулах, дэлгэц болон бүүт бусад хэсгийн видео бичлэг, дуу бичлэг хосолсон бүтээл туурвих, афтер видео, рийлүүд хийх, 2D, 3D зураг, урилга, постер хийх ажлуудыг; “Босс техноложи” ХХК нь хөтлөгч, урлаг соёлын одод, медиа баг, орон нутгийн төлөөлөгчдийн тээвэр, буудал, унааны захиалга, үйлчилгээг хариуцах ажлуудыг; “Оргил од дизайн” ХХК нь 400 ширхэг чихмэл хонь болон бэлэг бэлтгэх, загвар өмсөгч нарыг зориулалтын хувцсаар хангаж ажиллах үүргийг тус тус гүйцэтгэсэн.

Солонгос улсад бэлтгэл ажлыг хангах үүргийг БНСУ-ын “Борн тур” ХХК болон “Сүүм энтертайнмент” ХХК-иуд хариуцан ажилласан. Туслан гүйцэтгэгч компаниудтай БОАЖЯ болон БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны ажлын хэсэг гурван удаагийн онлайн уулзалт, хурал хийсэн. Тус арга хэмжээг Сөүл хотын “Grand Hayat” зочид буудлын хүндэтгэлийн “Grand ball room” танхимд зохион байгуулсан. Арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Ерөнхий сайдын ажлын алба, БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ, АЖБЗГазрын дарга В.Батчимэг тэргүүтэй төрийн байгууллагын төлөөлөгчид, БНСУ-ын улс төр, бизнесийн нөлөө бүхий хүндэт зочид, АЖМХолбооны тэргүүн дэд ерөнхийлөгч Т.Баттулга болон Солонгос зах зээлд үйл ажиллагаа явуулдаг тур операторуудын МОКТА холбооны гишүүн 16 компанийн төлөөлөл оролцсон

MEETS THE SKY

몽골은 땅과 하늘이 만나는 곳입니다

MONGOLIA



**YOU'LL
NEVER KNOW
UNTIL YOU MONGOLIA**

몽골에 가보기 전까지는 절대 알 수 없습니다



Тус арга хэмжээнд оролцсон компаниуд нь:

1. “Жи эс монголиа тур” ХХК
2. “Хадаг тур” ХХК
3. “Гөү номадс монголиа тур” ХХК
4. “Окэй трэйвэл” ХХК
5. “Увс тур” ХХК
6. “Жой монголиа трэйвэл” ХХК
7. “Эм жи тур” ХХК
8. “Нью вөрлд тур” ХХК
9. “Говь трэйвэл” ХХК
10. “PSW трэйвэл” ХХК
11. “AMTSH” ХХК
12. “Брайт фьючэ тур” ХХК
13. “Жуулчин” ХХК
14. “АРА” комплекс
15. “Эгэл хатан” ХХК
16. “Хайрхан ЛМТ” ХХК

Хэвлэл мэдээлэл, энтертайнментын салбарын нийт 400 гаруй зочид, төлөөлөгчид хүрэлцэн ирсэн. Аялал жуулчлалын салбарт контент үйлдвэрлэдэг 30 гаруй нөлөөлөгчдийг урьж төлбөртэй сурталчилгаа хийлгүүлсэн. Ирсэн зочид, төлөөлөгчдийн 10 орчим хувь нь улс төрч, төрийн байгууллагын албан хаагчид, 20 орчим хувь нь БНСУ-ын контент бүтээгч-нөлөөлөгчид, 70 орчим хувь нь аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд байсан. Хүндэт зочдын төлөөллөөс дурдвал БНСУ-ын Хүний нөөцийн сайд, Шинжлэх ухааны нийгэмлэгийн ерөнхийлөгч, МВС телевизийн захирал, KBS телевизийн хамт олон, аялал жуулчлалын шилдэг компаниуд болох “Муду тур”, “Хана тур”, “Кювон тур”, “Лотте тур” компаниуд, урлагийн одод, нэр хүндтэй нөлөөлөгчид байлаа. Монголоос очсон тур оператор компаниуд аяллын 5 чиглэлийн маршрутыг сурталчилж Монгол улсаа сурталчлав. Монгол гэр барьж нүүдэлчдийн ахуй амьдралыг илтгэсэн орчин бүрдүүлсэн бөгөөд тусгайлан Говь, Тэрэлж, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баян-Өлгий аяллуудыг илтгэсэн стэнд засаж, брошур тараан аяллуудын талаар зочдод тайлбарлав.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал 1: 2024.03.20, А/101 Гэрээ 1: 2024.03.21, 24/81"	168,368,000.00	2024.03.22 117,857,600.00	2024.11.01 50,510,400.00	168,368,000
"Тушаал 2: 2024.03.20, А/102 Гэрээ 2: 2024.03.21, 24/82"	673,378,500.00	2024.03.22 471,364,950.00	2024.03.25 202,013,550.00	673,378,500.00



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД



2024 оны 4-р сарын 25-30-ний өдрүүдэд "Бүгд Найрамдах Хятад Улс"-ын Гуанжоу, Хонгконг хотуудад зохион байгуулагдах Монгол улсыг сурталчлах "Go Mongolia Road show" болно.

MONGOLIA
· ALWAYS · MOVING ·

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, ХонгКонг, Гуанжоуд зохион байгуулсан “Go Mongolia” рөүдшоу

“Go Mongolia” roadshow арга хэмжээг БНХАУ-ын Бээжин, Гуан Жу хотууд болон БНХАУ-ын Засаг захиргааны онцгүй бүс болох Хонгконгт зохион байгуулсан. Тус арга хэмжээг БОАЖЯ, Монгол Улсаас Хонгконгт суугаа Ерөнхий консулын газар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, Нийслэлийн аялал жуулчлалын газар, АЖМХ болон түүний Хятад зах зээлийн салбар холбоо зохион байгуулав. Монгол Улсын дараах 16 тур оператор компани оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан.

Үүнд:

1. “Отгоодор” ХХК
2. “Этник трэйвэл” ХХК
3. “Монголиа сафари” ХХК
4. “Андын итгэл зүтгэл” ХХК
5. “И ти юу трэйвэл” ХХК
6. “Энжоу инн” ХХК
7. “Хорис байк адвэнчэр” ХХК
8. “Зэв хантинг сафари” ХХК
9. “Хөх чулуут” групп
10. “Монголиа трэйвэл” групп
11. “Монголиа визион тур” ХХК
12. “Рэтро трэйвэл” ХХК
13. “Айли трэйвэл” ХХК
14. “Аз жаргалтай аялал” ХХК
15. “Аял трэйвэл” ХХК
16. “Морнинг стар” ХХК

B2B уулзалтад хот болгонд Хятадын 40 орчим тооны аутбаунд аяллын компанийн төлөөлөгчид оролцсон. Арга хэмжээний үеэр монгол гэр барин уламжлалт зан заншил, идээ ундаа, үндэсний хувцас, урлаг, соёлоо сурталчлан танилцуулсан. Урлагийн тоглолтыг Улаанбаатар театр зохион байгуулсан. 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Гуанжоу хотод зохион байгуулсан рөүдшоунд Гуандун мужаас 80 гаруй аялал жуулчлалын байгууллагууд, 3 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 3 инфлюенсер оролцсон. 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Хонгконгын Александра зочид буудлын ёслолын танхим зохион байгуулагдсан рөүдшоунд Хонгконгийн Хятадын төрийн өмчит аялал жуулчлалын компани “China Travel Service”, Хонгконгийн аялал жуулчлалын компаниудын зөвлөл /Travel Industry Council of Hong Kong/, Хонгконгийн аялал жуулчлалын агентуудын холбоо /Federation of HK Chinese Travel Agents/ болон Хонгконг бүсийн 50 гаруй компанийн төлөөлөл хүрэлцэн ирсэн. 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Бээжин хотод зохион байгуулагдсан рөүдшоунд Бээжингийн 43 аяллын компанийн төлөөлөгчид оролцсон.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.30, А/229 Гэрээ: 2024.06.06, 24/243"	149,169,800.00	2024.06.12 104,418,860.00	2024.10.28 44,750,940.00	149,169,800.00



MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM



MONGOLIA TOURISM
ORGANIZATION
Legal entities of public law



HO CHI MINH CITY

TOURISM FESTIVAL 2024

4-7TH APRIL

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хо Ши Мин хотод зохион байгуулсан “Go Mongolia” рөүдшоу

“Go Mongolia” roadshow арга хэмжээг БНСВУ-ын Хошимин хотод “Ho Chi Minh Tourism Festival”-ийн үеэр зохион байгуулж, монгол үндэсний гэр, үндэсний хувцас, идээ, ундаа, урлагийн тоглолтоо сурталчилсан. Тус арга хэмжээг БОАЖЯ, Монгол Улсаас БНСВУ-д суугаа Элчин сайдын яам, АЖМХ, МИАТ ТӨХК хамтран зохион байгуулж, дотоодын 12 тур оператор компани оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан.

Үүнд:

1. “Амикус трайвэл” ХХК
2. “Казак тур” ХХК
3. “Леженд трэйвэл” ХХК
4. “Аян трэйвэл” ХХК
5. “Круз тур монголиа” ХХК
6. “Голден стиррап” ХХК
7. “Зэв антинг” ХХК
8. “Централ азиа трэйвэл” ХХК
9. “Голден Гоби тур” ХХК
10. “ТДМ Тур” ХХК
11. “Альфа бүлэг тур” ХХК
12. “Визит тү монголиа тур” ХХК

Монгол Улсын павильон нь тус үзэсгэлэнд оролцсон 57 павильоноос шилдгээр шалгарсан. Арга хэмжээний үеэр В2В уулзалтыг зохион байгуулж, Вьетнамын 40 гаруй аяллын компаниудын төлөөлөл оролцсон.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.30, А/227 Гэрээ: 2024.06.06, 24/241"	74,434,230.00	2024.06.12 52,103,961.00	2024.11.06 22,330,269.00	74,434,230.00

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

23-25
February 2024

ROAD SHOW IN BANGKOK
Event Arena 1st FL,
Central@CentralWorld



MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM



CENTRAL

Тайландын Хаант Улсын Бангкок хотод зохион байгуулсан “Go Mongolia” рөүдшоу

“Go Mongolia” roadshow арга хэмжээг Тайландын Хаант Улсын нийслэл Бангкок хотын “Central World” худалдааны төвд зохион байгуулж, монгол үндэсний гэр, үндэсний хувцас, идээ, ундаа, урлагийн тоглолтоо сурталчилсан. Тус арга хэмжээг БОАЖЯ, Монгол Улсаас Тайландын Хаан Улсаас суугаа Элчин сайдын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ, МИАТ ТӨХК хамтран зохион байгуулж, дотоодын 11 тур оператор компани оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан. Үүнд:

1. “Номадс адвенчур тур” ХХК
2. “Альфа бүлэг тур” ХХК
3. “Мон тай сино групп” ХХК
4. “Трэйвэл баадийс” ХХК
5. “Селена трэйвэл” ХХК
6. “Хөвсгөл трэйвэл” ХХК
7. “Аурора” зочид буудал
8. “Жуулчин Ханбогд” жуулчны бааз
9. “Хатан өгий” жуулчны бааз
10. “Базаар сапплай” ХХК

Үндэсний урлагийн “Богта” хамтлаг, монгол үндэсний хоол зууш хийх “Стэбл катеринг” компани, загварын шоу үзүүлэх МИАТ компанийн загвар өмсөгчид хамтран ажилласан. Арга хэмжээний үеэр В2В уулзалтыг зохион байгуулж, Вьетнамын 55 аяллын компаниудын төлөөлөл оролцсон. “Go Mongolia” павильоныг рөүдшоуны гурван өдөрт 40-50 мянган хүн үзэж сонирхсон.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.06.03, А/247 Гэрээ: 2024.06.06, 24/240"	64,834,795.00	2024.06.12 45,384,357.00	2024.11.06 19,450,438.00	64,834,795.00



MONGOLIA

· ALWAYS · MOVING ·



ЗОРИЛТ 2

**Олон улсын үзэсгэлэнд оролцож,
Монгол Улсыг сурталчлах**

ITB BERLIN 2024

DEFINE THE
WORLD OF TRAVEL.
TOGETHER.

Hall 3.2 | 127
5 – 7 MARCH 2024

One
step
ahead!

PENINSULA
TOURS



ITB
BERLIN

The World's
Leading
Travel Trade
Show*



“ITB Berlin 2024” ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн

ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулагдсан “ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд БОАЖЯ-ы дэмжлэгтэй Монголын Аялал Жуулчлалын Холбоо ТББ-ын ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж Монгол Улсын аялал жуулчлалын 11 компани оролцож Монгол Улсаа сурталчлах, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах, B2B уулзалт хийх үйл ажиллагааг идэвхтэй явуулав.

Үүнд:

1. “Цолмон трэйвэл” ХХК
2. “Жуулчин” ХХК
3. “Нью жуулчин” ХХК
4. “Грэйт Чингис экспэдишн” ХХК
5. “А стар” ХХК
6. “Эксплор монголиа” ХХК
7. “Рагуса” ХХК
8. “Нона фамилий” ХХК
9. “Голден гоби” ХХК
10. “Твин ворлд” ХХК
11. “Блю силк” ХХК

БОАЖЯ, АЖМХ-ны төлөөлөгчид, ХБНГУ-д суугаа Аялал жуулчлалын болон Соёлын элч нар ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Мандахбилэгтэй уулзалт хийв. ЭСЯ-наас ХБНГУ-ын аялал жуулчлалын холбоодтой харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв. Монголын талын төлөөлөгчид ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, уур амьсгалын яамны Олон улсын аялал, жуулчлалын хэлтсийн дарга хатагтай М.Вэбер, Олон улсын аялал жуулчлал, эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга М.Мурза нарын албаны хүмүүстэй уулзалт хийсэн. Монгол Улсын төлөөлөгчид аялал жуулчлалын салбар дахь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ХБНГУ-ын Үндэсний аялал жуулчлалын холбоо, Адал явдалт аялал жуулчлалын нийгэмлэг, ITB Берлин олон улсын үзэсгэлэнгийн төв салбар, ITB Хятад салбар, BBC Глобал ньос, БНХАУ-ын Аялал жуулчлалын холбоо, БНЭУ-ын ОТМ эвент зэрэг байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлүүдээ тодорхойлсон. Тус үзэсгэлэнд 170 гаруй орны 5,500 оролцогч бүртгүүлэн оролцсон. Монголын Аялал Жуулчлалын Холбоо ерөнхий зохион байгуулалтыг хариуцан ажилласан. БОАЖЯ-ны газрын дарга В.Батчимэг, АЖМХ-ны ажлын албаны дэд дарга Б.Цэцэгмаа нар Монголын аялал жуулчлалын салбарыг төлөөлөн уулзалтуудад оролцсон.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.03.21, А/104 Гэрээ: 24/100"	64,936,563.00	2024.04.17 13,000,000.00	2024.06.25 (7,455,594) 2024.06.27 (44,480,969) 51,936,563.00	64,936,563.00



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



The 39th Seoul International Travel Fair



May 9th (Thu) ~ 12th (Sun), 2024
COEX A Hall

Concurrent Event: (with the support of UNWTO)
The 3rd World Tourism Industry Conference

“SITF 2024” БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд 50 орны 400 компани 500 павильонд байрлаж оролцсон. 2024 оны үзэсгэлэнд Монгол Улсаас оролцох үйл ажиллагааг Ч.Батхуяг Тэргүүнтэй Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбоо зохион байгуулсан. Тус үзэсгэлэнд Монголын 11 тур операторын төлөөлөл 36мкв талбайг түрээслэн оролцов. Үүнд:

1. “Альфа” зочид буудал
2. “Бүрэн” жуулчны бааз
3. “Централ азиа трэйвэл” ХХК
4. “Круз тур монголиа” ХХК
5. “Говийн анар” жуулчны бааз
6. “Говийн Баянбүрд” жуулчны бааз
7. “Говийн өргөө” жуулчны бааз
8. “Гранд говь” жуулчны бааз
9. “Очир тэнүүн тур” ХХК
10. “Рагуса” ХХК
11. “Сүнжин” групп

2024 оны үзэсгэлэнг 50,000 гаруй хүн үзэж сонирхсон. 2024 онд Монгол Улс тохижилтгүй хоосон талбай дөрвийг авч өөрсдийн загвар дизайнаар нэмэлт зардал гаргаж тохижуулсан. SITF 2024 үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн бөгөөд нийт 28 жагсаалт бүхий ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үзэсгэлэнд оролцогчдын нислэгийн тийз болон тээвэрлэх ачаанд МИАТ ТӨХК нь хөнгөлөлт үзүүлж дэмжсэн. Монголын талын оролцогч байгууллагууд В2В, В2С уулзалтуудыг 09-10 –ны өдрүүдэд СОЕХ үзэсгэлэнгийн Е зааланд хийсэн. Үзэсгэлэнгийн төв тайз дээр монгол үндэсний урлагийн тоглолтыг 11 удаа, өөрсдийн төв павильоны урд 8 удаа хийж, улс орноо сурталчилсан. Монголын төв павильонд оролцогч байгууллагууд өөрсдийн аяллыг сурталчилсан. Тус үзэсгэлэнгээс Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо “Шилдэг Пи Ар” шагналыг авсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.07.02, А/305 Гэрээ: 2024.07.09, 24/338"	60,512,500.00		2024.11.01 60,512,500.00	60,512,500.00

“Tourism Expo Japan 2024” Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, Монгол-Японы Аялал Жуулчлалын Холбоо, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас 10 байгууллагын 40 төлөөлөл Япон улсын Токио хотноо 2024 оны 09 дүгээр сарын 26, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Travel Expo Japan-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаа сурталчлан таниулахаар 36м2 талбайг түрээслэн оролцсон. Тус үзэсгэлэнд 80 улсын 1,384 хувийн хэвшлийн байгууллагууд оролцсон бөгөөд ойролцоогоор 4 өдрийн хугацаанд 182,900 хүн арга хэмжээний танхимд нэвтэрсэн. Монгол Улсаас оролцсон дараах 10 байгууллага нь 4 хоногийн хугацаанд урьдчилсан байдлаар 200 байгууллага, 74 хувь хүнтэй уулзалт хийсэн. Үүнд:

1. “Жуулчин” ХХК
2. “Нью Жуулчин” ХХК
3. “Эйч & Эй фриэндшип” ХХК
4. “Жамогранд” ХХК
5. “Хасабэ интэрнэйшнл” ХХК
6. “Летс трэйвэл” ХХК
7. “Айрис тур” ХХК
8. “Алтан Тур” ХХК
9. “Аеро монголиа” ХХК
10. “Хүннү эйр” ХХК

АЖМХ-ны Ажлын албаны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Тэнгисболд нар Японы аялал жуулчлалын төрийн байгууллагуудтай ирээдүйн хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулсан. ЖАЙКА олон улсын байгууллагатай Монголд хэрэгжүүлж буй аялал жуулчлалын холбогдолтой төслийг үргэлжлүүлэх талаар, Японы Газар Дэд Бүтцийн Яамтай нислэгийн асуудлаар, JNTO байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх чиглэлээр, Нагасаки мужийн аялал жуулчлалын газар, Мацура хотын даргатай ажиллах хүчний сургалт, судалгаа, туршлага солилцох, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж буй газруудтай уулзалтуудыг тус тус хийсэн.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.09.30, А/47 Гэрээ: 2024.10.28, 24/176"	138,500,000.00		2024.12.19 138,500,000.00	138,500,000.00

China Outbound Travel & Tourism Market

CO T T M

2024

16-18 October 2024

New Hall, National Agricultural Exhibition Center, Beijing

China Outbound Travel & Tourism Market (COTTM) БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

БНХАУ-ын аутбаунд аялал жуулчлалын хамгийн том "China Outbound Travel & Tourism Market - COTTM" үзэсгэлэн нь 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 18-ны өдрийг хүртэл Бээжин хотын Хятадын Үндэсний Хөдөө Аж Ахуйн Үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдсан бөгөөд уг үзэсгэлэнд 7 тур оператор компани 30 мкв талбайд Монгол улсаа сурталчлан оролцсон.

1. “ETU трэйвэл” ХХК
2. “Актив эдвэнчур монголиа” ХХК
3. “Мега тур” ХХК
4. “Марко поло” ХХК
5. “Андын итгэл зүтгэл” ХХК
6. “Эдвэнчур монголиа” ХХК
7. “Бадар хундаганы эрдэнэс” ХХК

Тус үзэсгэлэнд дунджаар 5,000 гаруй БНХАУ-ын аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцдог бөгөөд дэлхийн аялал жуулчлалын салбарынханд (Хятадын "Бүс ба Зам"-ын орнуудад) хамгийн шинэлэг аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулдаг онцлогтой. Уг үзэсгэлэнд 52 улс орон, бүс нутгаас ирсэн 220 оролцогч, Хятадын 3,000 гадаад аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүд оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр Хятадын болон олон улсын аутбаунд компаниудтай В2В уулзалтыг зохион байгуулж Монгол Улсын аялал жуулчлалын нөхцөл байдал сурталчлан таниулж, өөрийн компанийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг шууд борлуулах боломжоор хангагдсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.09.30, А/47 Гэрээ: 2024.10.28, 24/176"	114,000,000.00		2024.12.03 114,000,000.00	114,000,000.00



wtm[®]

LONDON

5-7 November 2024

WTM London (World Travel Market London) ИБУИНВУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, Европ Зах Зээлийн Салбар Холбоо нь 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 07-ны өдөр хүртэл Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Лондон хотноо зохион байгуулагдсан World Travel Market (WTM) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт 2020 оноос хойш анх удаа оролцов. АЖМХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Барсболд нь WTM, Euronews, BBC Wildlife, NatGeo, WTTC, Wanderlust зэрэг салбарын томоохон төлөөлөлтэй хамтын ажиллагааны чиглэлийн уулзалтуудыг зохион байгуулав. Монголын тур оператор компаниуд Монгол Улс руу жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, түнш байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, Европын зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг эрэлхийлэн 250 орчим уулзалтууд хийв. Монгол Улсаас тус үзэсгэлэнг зорьж очсон байгууллагуудын 88.9 хувь нь оролцсон зорилгоо биелүүлсэн. Энэхүү бизнес уулзалтуудын үр дүнд 2025 онд ИБУИНВУ-аас ирэх жуулчид 10-25, Европоос ирэх жуулчдын тоо 15-20 хувиар нэмэгдэх магадлалтай. Европоос ирэх жуулчид Монгол Улсад дунджаар 12-14 хоног аялдаг ба нэг жуулчин тухайн аялалдаа дунджаар 2,500- 3,500 ам.доллар зарцуулдаг бөгөөд Монгол Улсын эдийн засагт (шууд ба шууд бусаар) гадаад валютын орлогыг нэмэгдүүлдэг чухал зах зээл юм. Тус үзэсгэлэнд Монгол Улсаас дараах аялал жуулчлалын компаниуд оролцов. Үүнд:

1. “Трэйвэл он” ХХК
2. “Актив энд адвенчер турс монголиа” ХХК
3. “Хорсбек адвенчер монголиа” ХХК
4. “Нью жуулчин турс” ХХК
5. “Монгол талын мэлмий” ХХК
6. “Жуулчин” ХХК
7. “Зэндмэн трэйвэл”
8. “Монголиа-грейт Чингис турс энд экспедишн” ХХК
9. “Монголиа Күэст” ХХК

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.10.24, А91 Гэрээ: 2024.10.31, 24/179"	192,500,000.00		2024.12.10 192,500,000.00	192,500,000.00



CITM



CITM

Exhibition Brochure

2024

Shanghai, China
Nov. 22-24, 2024



China International Travel Mart (CITM) БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, Хятад зах зээлийн салбар холбоо нь 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдөр хүртэл БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан China International Travel Mart (CITM) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 56 мкв талбайд Монгол Улсаа сурталчлан оролцов. China International Travel Mart (CITM) нь БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс зөвшөөрөгдсөн анхны олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн бөгөөд 2001 оноос жил бүр Шанхай, Куньмин хотод ээлжлэн зохион байгуулагддаг. Аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын агентлаг, зочид буудал, агаарын тээврийн компаниуд, соёлын байгууллагууд, музей болон бусад соёл, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид оролцдог. 2024 оны тус үзэсгэлэнд дэлхийн 47 улсын 500 гаруй, Хятадын 184, Монголын 12 тур оператор компаниуд оролцсон. АЖМХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Отгонбаатар байгууллагаа төлөөлж уулзалтуудад оролцов. Үзэсгэлэнгийн үеэр Go Mongolia үндэсний брэндингийн талаар мэдээлэл өгч сурталчлан таниулсан, Хятадын болон олон улсын инбаунд, аутбаунд компаниудтай B2B уулзалт зохион байгуулсан. Цагаан лавай чуулга ардын урлагийн тоглолт зохион байгуулж Монгол улсын ардын урлагийг сурталчилсан. Үзэсгэлэнгийн үр дүнд, Монгол Хятад хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх Монгол улсыг зорин ирэх Хятад жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, Монгол улсыг Хятадад сурталчлан таниулах таатай нөхцөлийг бий болгож, Хятадын аялал жуулчлалын компаниудад өөрсдийн үйл ажиллагаагаа таниулах болон аяллын бүтээгдэхүүнийг шууд борлуулах бололцоотой болсон.

1. “ETU трэйвэл”
2. “Ciel Voyage Mongolie” ХХК
3. Архангай аймгийн “Эртний нүүдэлчдийн өлгий аялал жуулчлалын холбоо”
4. “Альфа тийм турс” ХХК
5. “IELY трейвэл” ХХК
6. “Адвенчер монголиа” ХХК
7. “Амгалан баян отор” ХХК
8. “Эй би трэйвэл” ХХК
9. “Ретро трэйвэл” ХХК
10. “Аку гейм вөрлд” ХХК
11. “Отгоодор” ХХК

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.11.08, А/137 Гэрээ: 2024.11.20, 24/224"	168,682,700.00		2024.12.10 168,682,700.00	168,682,700.00

64^e FOIRE DU VALAIS
MARTIGNY *J'Y JOUE!*

27.09 –
06.10.24

ÇA JOUE?



“Foire du Valais”

Швейцарын Холбооны улсын Мартини хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн

Швейцарын Холбооны Улсын Валэ мужийн Мартини хотод 64 дэх жилдээ зохион байгуулагдсан “Валэгийн Үзэсгэлэн”-д Монгол Улс хүндэт зочноор оролцов. 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 10 өдрийн турш үргэлжилсэн тус үзэсгэлэнд олон улсын 400 гаруй байгууллага үйл ажиллагаагаа сурталчлан оролцож, 300 мянга гаруй хүн үзэж сонирхсон. Монгол Улс 10 дугаар сарын 02-ны өдөр “Go Mongolia” соёлын өдөрлөгийг цогц хэлбэрээр зохион байгуулж, Монгол Улсын аялал жуулчлалын салбарын танилцуулга мэдээллийн арга хэмжээнд Швейцарын төрийн болон орон нутгийн байгууллага, аялал жуулчлалын холбоо, тур агентлаг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагуудын 150 гаруй зочид төлөөлөгчдийг урин оролцуулав. . Тус арга хэмжээг нээж Элчин сайд, Байнгын төлөөлөгч Д.Гэрэлмаа, Швейцарын Үндэсний зөвлөл (Парламент)-ийн гишүүн, Гадаад харилцааны хорооны дарга Л.Верли нар үг хэллээ. Мөн “Foire du Valais” үзэсгэлэн яармагийн Ерөнхийлөгч В.Клаева, Валэ мужийн Эдийн засгийн сайд К.Дарбеллаи нар үг хэлэв. АЖМХ-ны Стратеги, гадаад хамтын ажиллагааны дэд дарга Б.Цэцэгмаа илтгэл тавьж, Монгол Улсад 20 дахь удаа аялсан Швейцарын иргэн Г.Паскаль өөрийн сэтгэгдэл, дурсамжаа хуваалцсан. Элчин сайд Д.Гэрэлмаа Швейцарын “Le Chablais” радио, “Le Nouvelliste” сэтгүүлд ярилцлага мэдээлэл өгсөн. Үзэсгэлэнгийн гадна талбайд монгол гэр, үндэсний бөхийн барилдаан, шагайн харваа, бие биелгээ, морин хуур, ятга, хөөмийн үзүүлбэр зэрэг өв уламжлал, үндэсний соёл, урлагаа сурталчлан танилцуулав. Үндэсний язгуур хөгжмийн зэмсгийг метал хөгжимтэй хослуулж, этно-рок чиглэлээр уран бүтээлээ туурвидаг “Уухай” хамтлаг бүрэн хэмжээний тоглолт толилуулсныг 2,000 орчим хүн үзэж сонирхов. Тус үзэсгэлэнд оролцоход ССАЖЗЯ, ГХЯ, Швейцарын элчин сайдын яам, АЖМХ, МИАТ ТӨХК хамтран ажиллав. Монгол Улсаас аялал жуулчлалын зургаан компани оролцож өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулав. Үүнд:

1. “Бүтэлэ” Ресорт
2. “Жамогранд” ХХК
3. “Ихэр Дэлхий” ХХК
4. “Увс тур” ХХК
5. “Хүнү фейшн” ХХК
6. “Богц” ХХК

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
Тушаал: 2024.11.08, А/137	183,356,300.00	2024.11.01 40,000,000.00	2024.12.16 13,292,750.00	53,292,750.00

Говь ХК
(Байгууллагын нэр)

ЗАРЛАГЫН ПАДААН № ...

Go Mongolia

(Худалдан авагчийн нэр)

Органик тасал

(Тээвэрлэгчийн нэр, хаяг)

2024 он 01 сар 03 өдөр

№	Бараа материалын үнэ бүхий зүйлийн нэр, зэрэг, дугаар	Хэмжих нэгж	Тоо	Бүртгэлийн нэр		Худалдах үнэ	
				нэгж	бүгд	нэгж	бүгд
1	8650029616540	170x30	1000	орголт		99 ш	142,000
2	WA210001						14,652,000
3	8650029833800	160x30	1000	орголт		45 ш	138,000
4	WA210002						6,210,000
5	8650020672446						
6	SAS10133	1000		ipad		150 ш	378,000
7	Зөвшөөрсөн Даясан						52,200,000
8							
9							
	Дүн					294	73,062,000

Хүлээлгэн өгсөн эд хариуцагч:

Шалгасан нягтлан бодогч:

Д.Нижирдор

Хүлээн авсан:

Антонийн

8888 7584

Р

Мерчендайзын бүтээгдэхүүний багц

Монгол Улс 2023 онд олон улсад "Welcome to Mongolia" үндэсний брэндийг тунхаглаж, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг дэмжих бодлогыг дэвшүүлэн, төр, хувийн хэвшил түншлэлийн хамтын ажиллагааны эрхзүйн орчноо тодорхой болгож, маркетингийн зардлуудаа нэгтгэж, олон улсын тавцанд хамтран ажилах болсон.

2024 онд Монгол Улсын үндэсний нэгдмэл үнэт зүйлийг илэрхийлэх утга бүхий "MonGolia, Always Moving" брэндийг дэлхий дахинаа зарлан, аялал жуулчлалыг идэвхжүүлэн улс орны хөгжлийн өнгө төрхийг илтгэж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэн, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн олон улсын нүүр царай болгох төлөвлөгөөтэйгөөр энэхүү арга хэмжээг зохион байгуулсан байна.

Мөн "Go MonGolia, Always Moving" бренд бүтээгдэхүүний багцын танилцуулгын хүрээнд Швейцарын Холбооны Улсын Давос хотод болсон Дэлхийн эдийн засгийн 54 дэх чуулга уулзалтад "Go Mongolia" брэндийн ач холбогдол, хүрсэн үр дүн, Монгол Улсын эдийн засгийн сэргэлт зэрэг олон улсын төлөөлөгчдөд дэлгэрэнгүй танилцуулсан байна.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
Тушаал: 2024.10.09, А/73 Гэрээ: 2024.07.09, 24/328	63,390,000.00	2024.12.19 63,390,000.00		63,390,000.00



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

ЗОРИЛТ 3

**Маркетинг, сурталчилгаа, цахим
шилжилтийг дэмжих**

 <p>安縵塔迦 ★★★★★ 4.9/5 · 23則評價</p> <p>CNY 17,229</p>	 <p>琅勃拉邦瑰麗酒店 ★★★★★ 4.8/5 · 55則評價</p> <p>CNY 13,278</p>	 <p>普瓦公館酒店 ★★★★★ 4.8/5 · 45則評價</p> <p>CNY</p>
---	--	---

超值優惠




Trip.com | MONGOLIA
MONGOLIA ALWAYS MOVING
BOOK NOW >



Trip.com
Master
機票
勁

已收藏 | 已瀏覽

	<p>美居海景輕奢公寓 (泉州東海泰禾店) ◆◆ 4.6/5 很好 371則評價</p>	 <p>東... ◆◆ 4.</p>
---	--	--



不入蒙古境 不解其風情

YOU WILL NEVER
FORGET YOUR TRIP TO
MONGOLIA

GO 美于蒙古國

Өвлийн аялал жуулчлалыг азийн зах зээлд сурталчлах

БНХАУ-д байршилтай **ctrip.com** онлайн аяллын агент (ОТА)-тай хамтран ажиллах гэрээг ССАЖЗЯ байгуулсан бөгөөд Монголын өвлийн аялал жуулчлалыг олон улсад сурталчлах зорилготой. Тус платформд орох мэдээллүүдийг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Сурталчилгааг 2025 оны 01 дүгээр сарын эхний хоёр долоо хоногт явуулна.




Mongolian Leading eWallet.

We accept



Гадаадын жуулчдын төлбөр тооцоо хийх техникийн боломжийг нэмэгдүүлэх

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр “Хайпэй” ХХК-тай “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан. Тус компани нь 2023 оны 01 дүгээр сард Монгол Улсад Wechat Pay-ээр төлбөр тооцоо төлөх боломжийг нээсэн.



Гадаадын жуулчдын төлбөр тооцоо хийх техникийн боломжийг нэмэгдүүлэх

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр “Хайпэй” ХХК-тай “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан. Тус компани нь 2023 оны 01 дүгээр сард Монгол Улсад Wechat Pay-ээр төлбөр тооцоо төлөх боломжийг нээсэн.



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2

Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх, аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн хөгжүүлэх

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 4.1.2-д “Аялал жуулчлалыг дэмжсэн зөөлөн дэд бүтцийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.”; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.3-д “үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.”; Мазаалай баавгайг үндэсний бахархалт амьтнаар зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 437 дугаар тогтоолын 1-д “2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан

"Мазаалай баавгайг үндэсний бахархалт амьтан"-аар зарласугай.", 2-д "Мазаалай баавгайг үндэсний болон олон улсын хэмжээнд таниулах хүрээнд холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг..."; Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 458 дугаар тогтоол; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.3-д "үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.", 8.2-д "Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ."; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5-д "Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.7-д "аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх"; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.4-д "аялал жуулчлалын сурталчилгааны дүрс бичлэг, зурган контент, гадаад сурталчилгааны хэвлэмэл материалыг боловсруулж түгээх ажлыг зохион байгуулах", 4.3.7-д "олон улсын нэр хүндтэй, олон үзэгчтэй хэвлэл мэдээллийн агентлагуудаар Монгол Улсын сурталчилгаа нэвтрүүлэх", 4.3.8-д "олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх", 4.4.9-д "аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, цар хүрээг өргөжүүлэх", 4.4.13-д "аялал жуулчлалын идэвх багатай 9-5 дугаар сард зохион байгуулагдаж байгаа аялал жуулчлалын арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх", 4.4.14-д "шашин, соёл, спорт, адал явдалт аялал, техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтийг агуулсан улирлын хамаарал багатай аялал жуулчлалын төрөл хэлбэрийг бодлогоор дэмжих", 4.4.17-д "нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх" гэж заасныг тус тус үндэслэн



MONGOLIA

· ALWAYS · MOVING ·



ЗОРИЛТ 1

Аялал жуулчлалын эвент, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг (i) хэрэгжүүлэн зохион байгуулах, (ii) дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

**БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ**

2024.02.01-02

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
**БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ**

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
**БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ**

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
**БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ**

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
**БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ**

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
ЭХЭНДЭГЭЭР

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
ЭХЭНДЭГЭЭР

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
ЭХЭНДЭГЭЭР

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН
ЭХЭНДЭГЭЭР



Монгол Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах

Монгол Улс аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилтыг баримталж байгаа бөгөөд байгалийн үзэсгэлэнт орчин, нүүдэлчин соёлын өв, өргөн уудам газар нутгийн онцлог зэрэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах суурь нөхцөл болж байна. Дэлхийн хэмжээнд аялал жуулчлалын салбар 2019 онд 1.5 тэрбум жуулчин хүлээн авч, 1.5 их наяд ам.долларын орлого бүрдүүлсэн нь салбарын ач холбогдлыг илтгэнэ. Монгол Улсын хувьд энэ боломжийг бүрэн ашиглахын тулд төрийн бодлого, эрх зүйн орчны шинэчлэл, дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх, хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчилж, тусгай хамгаалалттай газар нутгийг аялал жуулчлалын зориулалтаар зохистой ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнтэй уялдуулан Усны тухай, Ойн тухай зэрэг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, стандарт хангах нөхцөлд газар олголт, ашиглалтыг уян хатан болгосон. Түүнчлэн нисдэг тэрэгний зогсоолыг 102 байршилд төлөвлөх, Хөвсгөл нуурын эрэг дагуу кабель тээвэр, усан тээврийн шугам нэвтрүүлэх зэрэг дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Олон улсын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх үүднээс Япон, Канад, Герман, БНСУ болон Европын 34 орны иргэдийг 30 хүртэл хоногийн хугацаанд визийн шаардлагаас чөлөөлсөн бөгөөд цахим визийн системийг жигдрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 110 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт газрын төлбөрийн 50–100 хувийн хөнгөлөлтийн боломж зэрэг бодит боломжууд нээгдээд байна. Цаашид тансаг зэрэглэлийн үйлчилгээ, олон улсын аялал жуулчлалын брэндүүдийг нэвтрүүлэх, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, контент сурталчилгааг олон улсын түвшинд өргөжүүлэх шаардлагатай байна. Иймд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, хөрөнгө оруулалт татах тогтвортой, ил тод, найдвартай орчныг бүрдүүлэх чиглэлд цаашид тууштай ажиллах шаардлагатай.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.06.07, А/265 Гэрээ: 2024.06.20, 24/291"	30,000,000.00	2024.06.25 21,000,000.00	2024.12.19 9,000,000.00	30,000,000.00



“Go Mongolia” үндэсний брэндийг самбарт байршуулж, олон нийтэд сурталчлах

Монгол Улсыг нэгдсэн өнгө төрхтэйгөөр гадаадад сурталчлах "Go Mongolia" үндэсний брэндийг сурталчлах ажлын зорилго нь “Монголд зочлох жил”-ийн хүрээнд “Go Mongolia” үндэсний брэндийг монгол болон олон улсад таниулан сурталчлах, “Always Moving” уриа үгийг олон нийтэд түгээх, хоногшуулахад оршино. “Go Mongolia” үндэсний брэндийг УБ хотын 6 дүүрэг байршуулсан. Гүйцэтгэгч Си Си Ти Эс ХХК, Си Ар Си Жи ХХК, Глобал Сайкл ХХК-иуд нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - “Go Mongolia” түлхүүр үгийг ашиглан сурталчилгааны контент, зураг загварыг гаргасан; - Зураг загварын дагуу дотоодын болон гадаадын сурталчилгааны самбаруудад байршуулах судалгааг гаргасан; - Төлөвлөлтийн дагуу сурталчилгааны хэвлэмэл контентуудыг 1,09*1,54 метр хэмжээ бүхий 180 ширхэг самбарт суурилуулан Улаанбаатар хотын зургаан дүүргийн нутаг дэвсгэрт байршуулсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.30, А224 Гэрээ: 2024.05.31, 24/191"	50,000,000.00	2024.06.17 35,000,000.00	2024.11.01 15,000,000.00	50,000,000.00



Ministry of Culture,
Sports, Tourism and
Youth of Mongolia

MONGOLIA
· ALWAYS · MOVING ·



**MONGOLIA TOURISM
ORGANIZATION**
Legal entities of public law

TOURISM WEEK 2025



2025.02.10-15

“Аялал жуулчлалын долоо хоног 2024 /Tourism Week 2024/” арга хэмжээ

Аялал жуулчлалын олон улсын хөрөнгө оруулалтын чуулган

Монголын аялал жуулчлалын салбарын бүх талын оролцогчдыг хуран цуглуулж, салбарын өнөөгийн байдал, цаашид баримтлах хөгжлийн бодлогын талаар нээлттэй чуулан хэлэлцэх зорилготой “Аялал жуулчлалын долоо хоног 2024 /Tourism Week 2024/” форумыг 2024 оны 04 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Ерөнхий зохион байгуулагчаар Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, хамтран зохион байгуулагчаар Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороо, БОАЖЯ, Аялал Жуулчлалын Боловсрол Хөгжлийн Нийгэмлэг, Аялал Жуулчлалын Оюутны Нэгдсэн Холбоо ажилласан. Монголын аялал жуулчлалын салбарт анх удаа зохион байгуулагдсан тус форумын 7 өдрийн үйл ажиллагаанд нийт 3,780 зочид, төлөөлөгчид оролцсон. Энэхүү арга хэмжээнд шийдвэр гаргах эрх бүхий төрийн байгууллагын төлөөлөгчид, 21 аймгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд, салбарын томоохон байгууллага, аж ахуйн нэгжүүд, шинээр аялал жуулчлалын бизнес эрхэлж байгаа компаниуд, аялал жуулчлалын чиглэлээр суралцаж байгаа оюутан залуус, гадаадын зочид төлөөлөгчид зэрэг олон талын оролцогчдыг хамруулсан нь тун чухал ач холбогдолтой байсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.03.21, А/107 Гэрээ: 24/101"	800,000,000.00	2024.04.17 (200,000,000) 2024.04.25 (100,000,000) 2024.06.12 (190,000,000) 2024.06.14 (70,000,000)" 560,000,000.00	2024.12.30 5,320,000.00	565,320,000.00



Өдөр 1:

Аялал жуулчлалын форум

(850 оролцогчтой, Төрийн ордонд, салбар хуралдаан Блю Скай зочид буудалд болов)

Форумын үйл ажиллагааг Төрийн ордонд БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Золбадрал тэргүүтэй зочид үг хэлснээр нээсэн. Үдээс хойш дараах салбар хуралдаанууд болов.



Өдөр 2:

Аялал жуулчлалын академи (300 оролцогчтой, Блю скай зочид буудалд болов)

Академи нь гурван танхимд зэрэг өрнөсөн бөгөөд

Танхим 1: Аялал жуулчлалын салбар байгууллагуудын дарга, удирдлагуудад зориулан соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, зочлох үйлчилгээний бизнесийг удирдах, бизнесийн чанар сэдэвт сургалтуудыг орсо.

Танхим 2: Аялал жуулчлалын салбарт шинээр бизнес хийхээр төлөвлөж байгаа хүмүүс болон “Start-up” компаниудад зориулсан, неографик ашиглаж харилцагчийг татах, бизнес төлөвлөлт ба бизнес модель зэрэг сургалтууд орсон.

Танхим 3: Төрийн албан хаагчид болон 21 аймгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдэд зориулсан сургалтууд орсон.



Өдөр 3:

Аялал жуулчлалын B2B уулзалт (200 компани, 1,200 оролцогчтой, Корпорэйт энд Конвэшн центрт болов)

Жуулчны бааз, зочид буудал, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч болон тур операторуудын уулзалт болж, мөн бизнес эрхлэгч байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүнийг сурталчилсан.



Өдөр 4, 5:

Аялал жуулчлалын олон улсын хөрөнгө оруулалтын чуулган Аялал жуулчлалын олон улсын хөрөнгө оруулалтын чуулган (1000 оролцогчтой, 2 өдрийн турш Корпорэйт энд Конвэшн центрт болов)

Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын чуулган буюу дөрөвдөх өдөр “Плэй тайм”, “Чингис 21” төслүүдийн танилцуулга, тав дах өдөр шинэ төслийн “Тогтвортой аялал жуулчлалын танилцуулга”-ыг ЖАЙКА олон улсын байгууллагын мэргэжилтэн С.Макино, “Хил орчмын аялал жуулчлал”, “Цайны замын аялал жуулчлал” төслийн танилцуулгуудыг БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг тус тус хийсэн.

Форумын үед 6 төслийн танилцуулга хийгдэж, 7 санамж бичиг байгуулагдсан.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



СОЕЛЫН ЯАМ



НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАСАР



MAZAALAT

INTERNATIONAL SNOW & ICE FESTIVAL



2024
01.14-02.08

 **SKY
RESORT**

“Мазаалай” олон улсын цас мөсний наадам (Геннисийн рекорд тогтоолгох үйл ажиллагаа)

“Мазаалай” олон улсын цас мөсний наадам нь Улаанбаатар хотод анх удаа олон улсын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 02 дугаар сарын 08-ны хооронд зохион байгуулагдсан. Ерөнхий зохион байгуулагчаар БОАЖЯ, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, хамтран зохион байгуулагчаар Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Монголын Үндэсний Мөсөн Урлалын Холбоо, Стэппэ арена ХХК, Их тойнт урлал ХХК, Зэт мюзик ХХК, Лазер икс ХХК, Скай резорт, Play entertainment ажилласан. Туслан гүйцэтгэгч байгууллагууд эх мазаалай ба түүний бамбаруушуудыг дүрсэлсэн 52 ширхэг мөсөн баримал, 50 метр урт мөсөн гулсуур, мөсөн гулгалтын талбай зэргийг бүтээн байгуулсан. Нэг цагийн дотор хамгийн олон буюу 408 хүнийг мөсөн гулсуураар гулсуулж Гиннесийн дэлхийн дээд амжилтыг тогтоосон. Олон улсын мөсөн сийлбэрийн уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд 6 орны 25 уран сийлбэрч 12 төрлийн бүтээл урласнаас тэргүүн байрыг Франц улсын баг, дэд байрыг Монгол Улсын баг, гуравдугаар байрыг ОХУ-ын Саха улсын баг тус тус эзэлсэн. Арга хэмжээг зохион байгуулахад гаргасан нийт зардлын хэмжээ 1,765,082,312 төгрөг.

Нийт төсвийг Байгаль орчин аялал жуулчлалын яам 765,082,312 төгрөг, Нийслэлийн аялал жуулчлалын газар 50,000,000 төгрөг, Хувийн хэвшлийн ивээн тэтгэлгээр Таван богд групп 350,000,000 төгрөг, Гранд хөлөг девелопмент ХХК 350,000,000 төгрөг, Эм Си Эс групп 250,000,000 төгрөг болон хиймэл цас, цахилгаан хангамжийн зардал 100,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллав.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.03.21, А/108 Гэрээ: 24/102"	765,082,312.00	2024.04.17 (200,000,000) 2024.04.25 (100,000,000) 2024.05.20 (90,000,000) 2024.06.25 (235,557,618.4) 625,557,618.4	2024.1.01 139,524,000.00	765,081,618.4



“Нэг жуулчин-Нэг хонь”, “Хөх баавгай” хөтөлбөр

2023 оны 11 дүгээр сард “Нэг жуулчин-Нэг хонь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талт хамтын ажиллагааны санамж бичигт БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ, Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн Ерөнхийлөгч Ц.Баатарсайхан нар гарын үсэг зурсан. Хөтөлбөрийн гүйцэтгэгчээр Булган аймгийн аялал жуулчлалын холбоо, “Хөх сүрэг” ХХК, “Честный” ХХК ажилласан. 2024 оны 05 дугаар сарын 3-13 –ны өдрүүдэд Булган аймгийн 16 сумын малчин өрхүүдэд хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 1,552 малчин өрх бүртгүүлсэн. Тус хөтөлбөрийн зорилго нь БНСУ-аас жуулчдад хонь бэлэглэх бөгөөд тухайн хонины эзэн аппликейшнаар дамжуулан малчны илгээсэн сонирхолтой зураг, бичлэгүүдийг үзэж сонирхоно. Жил бүр хонины эзнийд зочлох боломжтой. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд гар утасны Go Mongolia, Go Nomads нэртэй аппликейшныг АйСиТи групп ХХК-аар бүтээлгэн ашигласан. Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбооны тур оператор компаниуд хөтөлбөрийг дэмжиж, сурталчлан ажиллав.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.04.08, А/139 Гэрээ: 2024.04.12, 24/110"	100,000,000.00	2024.01.18 (35,000,000) 2024.04.12 (25,000,000) 60,000,000.00	2024.12.27 40,000,000.00	100,000,000.00

NASSUMMIT.
THE CREATORS GATHERING



NASSUMMIT.
MONGOLIA

“Nas Summit Mongolia 2024” форум

“Нас Саммит” олон улсын уулзалт Монгол Улсад хоёр дахь удаагаа 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан. Гадаадын 9, дотоодын 6 нөлөөлөгчдийн илтгэлийг 4,000 хүн үзэж сонссон. Бүх нөлөөлөгчид өөрсдийн сошиал сувгийг ямар шалтгаанаар эхлүүлж байсан, анх ямар бэрхшээлүүд тулгарч байсан талаар яриагаа эхлүүлсэн нь үзэгчдийн сонирхлыг ихээр татсан. Нөлөөлөгчид, контент бүтээхэд англи хэлний ач холбогдол, үзэлт ихтэй видео хэрхэн хийх, контент бүтээх нь дэлхийг өөрчилж чадах уу гэх зэрэг сэдвүүдээр илтгэлээ тавьсан.

Нас Дейлигээс “Хамгийн өндөр тестостронтой улс”, “Монголын шидэт ямаанууд”, “Алдарт ээжүүдийн нутаг” гэх гурван бичлэг хийж фейсбүүк, инстаграм, youtube зэрэг платформууд дээр тавьж нийт 63,667,072 үзэлт авжээ. Гадаадын есөн нөлөөлөгчдийн бичлэгүүд нийт 68,449,725 үзэлт хүрсэн байна.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.04.08, А/140 Гэрээ: 2024.06.14, 24/277"	700,000,000.00		2024.12.03 700,000,000.00	700,000,000.00


SUNNY DAHYE



- 7 videos
- 4 image posts
- 30+ stories

TOTAL VIEWS: 1,750,000+

across 3 platforms



FIT AND TRAVEL



- 6 videos done
- 4 videos in progress
- 1 image post done

TOTAL VIEWS: 1.16M+

across 4 platforms



Creators Trip January 2024

NAS DAILY.

EXIT JACK



- 3 videos
- 5 image posts
- 10+ stories

TOTAL VIEWS: 315,000+

across 2 platforms




HYOJOO



- 4 videos
- 4 image posts
- 10+ stories

TOTAL VIEWS: 300,000+

across 4 platforms



“Nas Daily Q1, Q2” нөлөөлөгчдийн контент бүтээх өвлийн аялал

“Монголд зочлох жил”, “Go Mongolia” үндэсний брэндийн хүрээнд БОАЖЯ, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ хамтран эх орноо сурталчлах зорилгоор “Nas studios marketing management” ХХК-ийн нөлөөлөгчдийг урин өвлийн аялал жуулчлалыг сурталчлан таниулах зорилготой I, II улирлын аяллыг /2024.01.09 - 2024.01.16 болон 2024.02.29 - 2024.03.07/ зохион байгуулсан. I улирлын аялалд БНСУ-ын хоёр, БНХАУ (Хонгконг)-ын нэг, Япон улсын нэг, дөрвөн нөлөөлөгч туслахуудын хамт найм, Нас студиогийн бие төлөөлөгчийн хамт нийт есөн хүн ирсэн. Тэднийг Орхон, Булган, Архангай, Өвөрхангай аймгуудаар аялуулан “Нэг жуулчин-Нэг хонь” хөтөлбөрийн айлуудаар болон Архангай аймгийн АРА комплекст болсон “Winterland Ice Festival” өвлийн фестивалд зочлуулж контент бүтээлгэсэн. II улирлын аялалд БНХАУ-ын хоёр, Тайланд улсын нэг, нийт гурван нөлөөлөгч ирж Хөвсгөл аймгийн “Хөх Сувд” цас, мөсний баярт оролцон монголын өвлийн аялал жуулчлалын тухай контент бүтээсэн. Уг аялал нь 11 өдөр 10 шөнө үргэлжилсэн бөгөөд Хөх сувд, Бүргэдийн баяр гэсэн өвлийн фестивалиудаар зочилсон. Нийт 9 бичлэг, 15 имидж зурагтай пост орсон нь 7,7 сая үзэлттэй байна.

Үйл ажиллагааг дэмжин АПУ ХК 30 сая, Говь ХК 40 сая төгрөгийн хандив өгсөн. Нөлөөлөгчдийн контентыг ивээн тэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дурдвал, “Малчин” зочид буудал, “Баянмонгол” ресорт, “Ашид бэхи” зочид буудал, “Хангайн төгөл” зочид буудал, “АМТШ” ХХК, “Долоон нуга” ресорт, “Жуулчин тэрэлж” ресорт. Хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг дурдвал, “Тойлогт” жуулчны бааз, “Жаргант” жуулчны бааз, “50 100” зочид буудал.

Тус үйл ажиллагаа нь 2024 онд 500 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй дууссан бөгөөд 2025 онд үргэлжлүүлэн ажиллана.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
Тушаал: 2024.12.06, А/94	500,000,000.00	0.00	0.00	0.00




БНСУ-ын нөлөөлөгчдийг урьж, Монгол Улсыг сурталчлах

Монгол Улсын гадаад сурталчилгааг эрчимжүүлэх, цахим орчинд контент бүтээх ажлыг зохион байгуулах зорилгоор 2024 оны эхний таван сарын хугацаанд БНСУ-ын олны танил, нөлөөлөгч 12 инфлюенсерийг Монгол оронд урьж, тодорхой маршрутын дагуу Улаанбаатар хот болон Орхон, Булган аймгийн нутгуудаар аялуулсан. 1. Сошиал платформуудад олон мянган дагагчтай 12 нөлөөлөгчдийг байгалийн цогцолборт газруудаар аялуулж, монгол орны түүх, өв соёл, уламжлал, үндэсний хоол унд, малчин айлын амьдрал ахуй, таван хошуу арчилгаа, маллагааны талаар танилцуулсан. Нэг жуулчин-Нэг хонь хөтөлбөрийн хүрээнд 12 олны танил нөлөөлөгчид тус тус бүр нэг хонь бэлэглэсэн. 2. БНСУ-ын нэрт дуучин Пак Ён Так 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хугацаанд Монгол оронд хүрэлцэн ирж, БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнээс “Аялал жуулчлалын элч” батламж гардан авсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.07.09, А/314 Гэрээ: 2024.07.09, 24/327"	700,000,000.00			
"Тушаал: 2024.05.004, А/181 Гэрээ: 2024.05.29, 24/182"	59,800,000.00	2024.06.07 41,860,000.00	2024.11.01 17,940,000.00	59,800,000.00

Winterland ❄️ ice festival ❄️

ТАМИРЫН ЖАВАР 2024



Архангай аймаг,
Тамирын голын эрэг

2024.01.12-14

“АРА” өвлийн фестиваль

“АРА өвлийн фестиваль” нь улсын хэмжээнд анх удаа Архангай аймгийн Булган сумын нутагт орших Тамирын голын эрэгт зохион байгуулагдсан. Зохион байгуулагчаар БОАЖЯ, Соёлын яам, Архангай аймгийн ЗДТГ, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, Архангай аймгийн “Эртний нүүдэлчдийн өлгий” Аялал Жуулчлалын Холбоо ТББ, АРА комплекс, Нутаг хүнс трейд ХХК ажилласан. Нийт оролцогчдын тоо ойролцоогоор 30,000 хүн. Арга хэмжээний бүс рүү 5,000 орчим тээврийн хэрэгсэл нэвтэрсэн. Хөтөлбөрийн хүрээнд уралдаан тэмцээн, үндэсний уламжлал, соёл урлагийн 12 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Орон нутгийн эдийн засагт 3,0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг бий болгосон. “Нэг жуулчин – Нэг хонь” хөтөлбөрийн хүрээнд БОАЖ-ын сайд Б.Бат-эрдэнэ болон түүний ажлын хэсэг орон нутгийн 100 орчим малчдын уулзалтыг зохион байгуулсан. БНХАУ-ын Юньнань мужийн аялал жуулчлалын төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл, Хөлөнбуйр хотын аялал жуулчлалын компанийн төлөөлөл, ЖАЙКА олон улсын байгууллагын төлөөлөгчид болон Архангай аймгийн төр, хувийн хэвшлийн төлөөллүүд оролцсон бизнес уулзалтыг зохион байгуулсан. Энэхүү уулзалтын ач холбогдол нь Архангай аймаг болон бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд байсан. Фестивалийн үеэр орон нутгийн худалдаа, үйлдвэр эрхлэгчдийг түлхүү дэмжих зорилгоор Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран цагаан идээ, малын арьс, шир, ноос, ноолуур, нутгийн онцлогтой бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг худалдаа эрхлэгчдийг түлхүү татан оролцуулсан. Арга хэмжээг зохион байгуулахад гаргасан нийт зардлын хэмжээ 356,074,091 төгрөг. БОАЖЯ-наас 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.04.05, А/132 Гэрээ: 2024.05.14, 24/162"	30,000,000.00	2024.06.07 21,000,000.00	2024.11.01 9,000,000.00	30,000,000.00

ХӨХ БААВГАЙ
ХӨВСГӨЛ НУУР

ХӨХ СУВД
МӨСНИЙ БАЯР 2024

ХӨВСГӨЛ НУУРЫН ЭРЭГ
2024.03.02-03

“Хөх сувд” цас мөсний баяр

“Хөх Сувд мөсний баяр-2024” нь улсын хэмжээнд 2002 оноос эхлэн 22 дахь жилдээ Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан. Ерөнхий зохион байгуулагчаар Хөвсгөл аймгийн ЗДТГ, хамтран зохион байгуулагчаар БОАЖЯ, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ ажилласан. Туслан гүйцэтгэгч компаниуд (Их тойнт урлаг ХХК, Мянганы эгшиглэн ХХК, Тоонот медиа ХХК) нь мөсөн хотхон барих, мөсөн сийлбэр урлах, мэргэжлийн тайз босгох, уран бүтээлийн тоглолт зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Арга хэмжээнд оролцогчдын тоо ойролцоогоор 40,000 хүн. Үүнээс гадаадын 17 улсын 652 жуулчин ирсэн. Арга хэмжээний бүс рүү 2,498 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн. Хөтөлбөрийн хүрээнд уралдаан тэмцээн, үндэсний уламжлал, соёл урлагийн 28 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Улсын аварга шалгаруулах мөсөн баримлын анхны уралдааныг зохион байгуулсан. Нийт 198 хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагууд худалдаа, үйлчилгээ (гар урлал 48, үндэсний хувцас түрээслэх, зарах 48, тоглоом тоглуулах 19, бэлэн хувцас зарах 15, хүнсний худалдаа 20, халуун цай, кофе 10, эмийн ургамал зарах 3, бэлэг дурсгалын 8, шорлог 12, газ борлуулалт 1, хоол үйлдвэрлэл 54)-ний чиглэлээр ажилласан. Орон нутгийн эдийн засагт 2,5-3,0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг бий болгосон. Арга хэмжээг зохион байгуулахад гаргасан нийт зардлын хэмжээ 323,119,000 төгрөг. БОАЖЯ-наас 150 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.04.05, А/131 Гэрээ: 2024.04.19, 24/119"	150,000,000.00	2024.05.07 (45,455,594.1) 2024.05.07 (50,570,400) 95,965,994.1	2024.05.20 54,000,000.00	149,965,994.10



ДАШТ-ний Зооны байршил
Competition area



Мөсний загасчлалын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (ДАШТ)

Монгол Улсад анх удаа дэлхийн 20 дахь удаагийн “Мөсний загасчлалын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Архангай аймгийн Өгий нуур сумын нутагт орших Өгий нуур дээр зохион байгуулсан. Ерөнхий зохион байгуулагчаар “Монголын Загасчлалын Спортын Хороо” ТББ, хамтран зохион байгуулагчаар БОАЖЯ, Биеийн тамир спортын Үндэсний хороо, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ ажилласан. Тус тэмцээнд арван орон /Норвег, Латви, Литва, Казахстан, АНУ, Эстони, Монгол, Украин, Финланд, Швед/-ы 111 тамирчид оролцсон. Тэмцээнд хувийн дүнгээр алт, мөнгө, хүрэл медалийг Литва улсын 3 тамирчин эзэлсэн бөгөөд багийн дүнгээр алтан медалийг Литва, мөнгөн медалийг АНУ, хүрэл медалийг Украин улс тус тус эзэлсэн.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.04.08, А/138 Гэрээ: 2024.04.19, 24/118"	100,000,000.00	2024.05.06 70,000,000.00	2024.11.01 30,000,000.00	100,000,000.00

1997 оноос хойш



ГИННЕСИЙН ДЭЭД АМЖИЛТЫГ

ШИНЭЧЛЭН ТОГТООСОН

Өвлийн аялал жуулчлалын ууган эвент

"ТҮМЭН ТЭМЭЭНИЙ БАЯР- 2024"




Өмнөговь аймгийн, Даланзадгад хотноо, 2024 оны 02 сарын 1-3-ны өдрүүдэд

“Түмэн тэмээний баяр 2024”

“Түмэн тэмээний баяр-2024” нь улсын хэмжээнд 1997 оноос эхлэн 27 дахь жилдээ Өмнөговь аймагт зохион байгуулагдсан. Ерөнхий зохион байгуулагчаар “Гайхамшигт говь” ТББ, дэмжин ажиллагчаар БОАЖЯ, АЖМХ, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар ажилласан. Тус баярт оролцогчдын тоо ойролцоогоор 8,620 хүн байснаас гадаад улсын 120 гаруй жуулчид, зочид ирсэн. Тус арга хэмжээнд 7 аймгийн 25 сумын тэмээчид 400 орчим тэмээтэй оролцсон. Хөтөлбөрийн хүрээнд уралдаан тэмцээн, үндэсний соёл уламжлал, соёл урлагийн 9 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Орон нутгийн эдийн засагт 1,1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг бий болгосон. БОАЖЯ-наас 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.06.12, А/272 Гэрээ: 2024.07.01, 24/304"	20,000,000.00		2024.11.01 20,000,000.00	20,000,000.00

"Далины баяр-2024"



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН СУМАНД**

**2024.05.11-НИЙ
БЯМБА ГАРАГТ УУЛЗАЦГААЯ...**

“Далины баяр 2024”

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ нь Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2024.05.08-11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Үүнд: -Далий ягаан цэцгийн ач холбогдлыг сурталчлан таниулах, -Урлагийн олны танил болон залуу уран бүтээлчдийг оролцуулан урлагийн тоглолт зохион байгуулах, -Нийслэлийн болон орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг өргөн хүрээнд хамруулах, -Тухайн арга хэмжээг зохион байгуулахад дотоод, гадаадын жуулчны аюулгүй байдлыг хангах, -Дотоод, гадаадын жуулчны тоог гарган орон нутгийн иргэдэд хэдэн төгрөгийн орлого оруулсан талаар судалгаа гаргах. Далины баяр арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эгийн голын орчимд зохиогдсон бөгөөд хөтөлбөрийн дагуу 9 үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: -Бүх нийтийн алхалт, гүйлт, -Дасгал, бүжиг, -Нээлтийн үйл ажиллагаа, -Урлагийн үзүүлбэр, -“Эрдэнэбулган үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаа, -“Эрдэнэбулганы таван онцлог” үзэсгэлэн, -Уралдаан тэмцээн /олс таталт, буухиа, хөгжөөнт тэмцээн, хүүхдийн дугуйн уралдаан, элсний волейбол/, -Шүлгийн уралдаан, -Хаалтын шоу тоглолт /МУГЖ Б.Сарантуяа, МУГЗ Б.Батчулуун, Voice Mongolia шоуны ялагч Х.Ядам, Ц.Энгүүн, дуучин СТА Б.Гүрбадам, Р.Болортуяа, DJ н.Төгөлдөр/

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.04, А/193 Гэрээ: 2024.05.08, 24/169"	30,000,000.00	2024.06.12 21,000,000.00	2024.11.01 9,000,000.00	30,000,000.00



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОВСРОЛ,
ХӨГЖЛИЙН НИЙГЭМЛЭГ



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



GRAND TOUR-2024

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УЛСЫН ХХII ОЛИМПИАДАД

18

Их, дээд сургуулийн

350

гаруй оюутан оролцохоор
мэдүүлэг ирүүлжээ.



MONGOLIA
· ALWAYS · MOVING ·

“Гранд тур 2024” аялал жуулчлалын салбарын оюутны олимпиад

Аялал жуулчлалын мэргэжлийн хөтөлбөрүүдээр сургалт явуулдаг их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний ажлыг дэмжин урамшуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, бүх нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой “Гранд тур” олимпиадын ерөнхий зохион байгуулагчаар “Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг” ТББ ажилласан. Тус олимпиад нь хаврын улирал буюу 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд бизнес загварчлалын цахим тэмцээн, контент бүтээх тэмцээн, спорт явган аяллын тэмцээнүүдийг зохион байгуулсан. Намрын улирал буюу 09 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд мэргэжлийн онол, ур чадварын тэмцээн, эрдэм шинжилгээний бага хурал, аялал жуулчлалыг сурталчлах үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Хаврын улирлын олимпиадын төрлүүдэд нийт 18 сургуулийн 35 багш, 500 оюутан хамрагдсан. CESIM Service зочлох үйлчилгээний бизнес загварчлалын тэмцээний зохион байгуулалтыг Cesim service симуляцийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч, ШУТИС-ийн багш доктор Э.Ганбат удирдан зохион байгуулсан. Тус тэмцээнд 3 хүний бүрэлдэхүүнтэй 18 баг оролцсоноос тэргүүн байрт Отгонтэнгэр их сургуулийн баг, дэд байрт Хангай дээд сургуулийн баг, гуравдугаар байрт Олон улсын Улаанбаатар их сургуулийн баг тус тус шалгарсан. Аялал жуулчлалын салбарын статистик мэдээллээр Tourism infographic контент бүтээх тэмцээнд 17 сургуулийн бүрэлдэхүүнтэй 18 баг оролцсоноос тэргүүн байрт СЭЗИС-ийн баг, дэд байрт Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн баг, гуравдугаар байрт ШУТИС-ийн баг тус тус шалгарсан. Спорт-явган аяллын тэмцээнд 27 баг оролцон 7 төрлийн даалгавар гүйцэтгэснээс тэргүүн байрт Монголын үндэсний их сургуулийн баг, дэд байрт МУБИС-Биеийн тамирын сургуулийн баг, гуравдугаар байрт МУБИС-Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн баг тус тус шалгарсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.30, А/226 Гэрээ: 2024.06.06, 24/244"	15,000,000.00	2024.06.14 10,500,000.00	2024.11.01 4,500,000.00	15,000,000.00

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



УЛААНБААТАР АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗӨВИЙН ХУУЛИЙН ЭГТЭЭД



МИШЭЭЛ ЭКСПО

А Я Л А Л Ж У У Л Ч Л А Л Ы Н Ү З Э С Г Э Л Э Н

10_{ДАХЬ} УЛААНБААТАР ТРАВЭЭЛ

ЭКСПО 2024  MONGOLIA

05 САРЫН 24, 25, 26 | Мишээл Экспо ОУУХТ-Үзэсгэлэнгийн танхим



“Улаанбаатар Травел Экспо 2024” аялал жуулчлалын үзэсгэлэн


“Мишээл Экспо” олон улсын үзэсгэлэн худалдааны төвд зохион байгуулагдсан “Улаанбаатар Травел Экспо 2024” үзэсгэлэнгийн ерөнхий зохион байгуулагчаар “Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо” НҮТББ, хамтран зохион байгуулагчаар БОАЖЯ, НАЖГ, АЖМХ ажилласан. Тус үзэсгэлэнд Улаанбаатар болон орон нутгийн 87 байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцож, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлан борлуулсан бөгөөд 4,000 гаруй иргэд үзэж сонирхсон. БНСУ-ын Аялал жуулчлалын байгууллага (КТО)-ын суурин төлөөлөгчийн газар 17 байгууллагыг нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцуулсан. Үзэсгэлэнгийн үеэр аялал жуулчлалын салбарын платформ, технологийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулав. Үзэсгэлэн сонирхогчдод зориулсан аяллын олон төрлийн сэдвээр танилцуулга, зөвлөгөө, мэдээлэл өгөх арга хэмжээнүүд болон салбарын хүний нөөцийн өдөрлөг зохион байгуулагдсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.06.14, А/279 Гэрээ: 2024.06.20, 24/289"	30,000,000.00	2024.06.25 21,000,000.00	2024.07.16 9,000,000.00	30,000,000.00

Organizer

Media Partner

HORECA
CONTENT



April 5th, 2024

HOTEL • RESTAURANT • CATERING

HORECA

MONGOLIA CONFERENCE 2024

ЖУУЛЧДАА ДАЙЛАХ МОНГОЛ ЗООГ



Horeca Mongolia Conference 2024 VI чуулганы сэдэв: Жуулчдаа дайлах монгол зоог

Монгол үндэсний зоог, ундааг түгээн дэлгэрүүлэх, жуулчны цэс зохиох, төлөвлөхтэй холбоотой судлаач, эрдэмтдийн оролцоотой туршлага мэдээлэл солилцох, бүс нутгийн онцлог бүхий түүхий эд, материалыг орчин үеийн технологид суурилан инновац шингээн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн бий болгох, цэсэд нэвтрүүлэх, бодит туршлагаа хуваалцаж өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах, сурталчлах зорилготой “Жуулчдаа дайлах монгол зоог” Horeca Mongolia Conference-2024 зөвлөгөөнийг “Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ нь 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр UB Palace-д 6 дахь жилдээ зохион байгуулсан. Энэ удаагийн зөвлөгөөнийг (1) монголын уламжлалт зоог ба аялал жуулчлал, (2) монгол уламжлалт зоог, ундаа ба орчин үе, (3) монгол уламжлалт зоог, ундааг таниулах ба нөлөөл гэсэн гурван үндсэн сэдвийн хүрээнд хувааж 9 илтгэл хэлэлцүүлгийг явуулсан нь оролцогчдын хүсэл сонирхолд нийцсэн бөгөөд судлаачдын тавьж буй илтгэл нь судалгаанд суурилсан, монгол зоог, ундааг түгээн дэлгэрүүлэх шинэлэг санааг дэвшүүлж чадсанаараа ач холбогдолтой.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.05.31, А/241 Гэрээ: 2024.06.06, 24/242"	18,000,000.00	2024.06.12 12,600,000.00	2024.07.16 5,400,000.00	18,000,000.00

Өвлийн улиралд ажилладаг цахилгааны хөнгөлөлт авсан жуулчны баазууд

1	"Атар шим трейд" ХХК	Грийн кроун
2	"Хаан жимс Эс Би Ти" ХХК	Хаан жимс
3	"Вайт спринг" ХХК	Цагаанбулаг
4	"Бат тоонууд" ХХК	Цроохор нуга
5	"Өмнө зүүн говь" ХХК	Сүлд Ресорт
6	"ДНДХ" ХХК	Тэрэлж стар ресорт
7	"Дуут" ХХК	Дуут ресорт
8	"Хульж Ресорт" ХХК	Хульж Ресорт
9	"Соргог Ланд" ХХК	Долоон Нуга
10	Монленд ХХК	Бумбын орон
11	Жуулчин ХХК	Жуулчин тэрэлж ресорт
12	"Хужирт тур" ХХК	Хан хужирт цогцолбор
13	"Хилэнц холдинг" ХХК	"Хилэнц ресорт"
14	"Үзэсгэлэнт горхи Тэрэлж" ХХК	Үзэсгэлэнт горхи тэрэлж
15	"Тэргүүн тэлмэн" ХХК	Хонгор морьт
16	"Чингис хааны хүрээ" ХХК	Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолбор
17	"Глори ресорт Монголиа" ХХК	Глори ресорт
18	"Баян Трейвэл лодж" ХХК	Баян Монгол ресорт
19	"Би Тү Брос" ХХК	Бүтэлэ Ресорт
20	"Гайхалтай тур" ХХК	Арга билиг ресорт
21	"ЭЭЦЭ" ХХК	Хан-Оргил
22	"Саяан Радиан" ХХК	Ласт Фронтир
23	"Дуган хад жуулчин" ХХК	Дуганхад
24	"Манзушир Трейд" ХХК	Овооны энгэр
25	"Өнжүүл богд" ХХК	Өнжүүл богд
26	Уньтийн рашаан ХХК	Уньт рашаан
27	"Нууц Товчоо" ХХК	Монголын нууц товчоо
28	"Ультрасоник" ХХК	Ультра Грийн Ресорт
29	"Өнөр БСОБ" ХХК	Домогт мэлхий хад
30	Хустайн цогцолбор	Хустай жуулчны бааз
31	"Есөн их бэлгэ" ХХК	Тэнгэрийн элч
32	"О энд Партнерс" ХХК	Дрийм скай
33	Ашид бэхи ХХК	Ашид бэхи
34	МНХ ХХК	Янгирт
35	"Монгол Алтай травел" ХХК	Мираж кэмп
36	Хангайн төгөл тур ХХК	Хангайн төгөл
37	Түү мандал ХХК	Ган хадат
38	Ар гурван сайхан ХХК	Ар гурван сайхан амралтын газар
39	Монголий Вояж ХХК	Мөнхтэнгэр-2 Богд
40	Пийсвинд ХХК	Грийн Лодж
41	Баян харзаг ХХК	Монде тур
42	Хустайн Молцог элс ХХК	Молцог жуулчны бааз
43	Хүннү Ти Энд Ти ХХК	Хүннү тур
44	Хархорин Трэвел ХХК	Хар хорин хостел ресторан
45	Женко тур бюро ХХК	Чингисийн хөшөө цогцолбор
46	Мөнх хөх тэнгэрийн элч ХХК	Бөртэ ресорт
47	Мянган лант ХХК	Тэрэлж моунтайн лодж
48	Шаазгайтын нуруу ХХК	Байтаг богд
49	Жигүүр гранд	Баатар ван
50	Хонгор халиут ХХК	JM амралт
51	Гарьдийн шилтгээн ХХК	Чин чандмань
52	Хөвсгөл трэйвэл ХХК	Тойлогт
53	Ном-Ээл ХХК	Тэрэлж хилс лодж
54	Дүнхэн уулын буурал улиастай ХХК	Ресорт ворлд тэрэлж
55	Нью Пакс Монгол ХХК	Монголика буудал ресорт

Өвлийн улиралд ажилладаг жуулчны баазуудад үзүүлэх шөнийн цахилгааны хөнгөлөлт

2023 оны 10 дугаар сараас эхлэн 700 гаруй жуулчны бааз, амралтын газруудад мэдээлэл түгээсэн бөгөөд өвлийн улиралд үйл ажиллагаа эрхэлдэг 159 жуулчны баазууд судалгаанд хамрагдсан. Тус судалгаагаар цахилгааны төлбөрийн хөнгөлөлт нь жуулчны баазуудад бодит дэмжлэг болох нь тодорхойлогдсон. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30 өдөр хүртэл өвлийн улиралд үйл ажиллагаа явуулсан 55 байгууллагын хүсэлтийг цахилгааны нэхэмжлэхийн хамт хүлээн авч, түүнийг үндэслэн шөнийн цахилгааныг тарифыг хөнгөлөх тушаалын дагуу 70 хувийн буцаан олголтыг нийт 55 байгууллагад олгож дууссан. Цахилгааны хөнгөлөлтөнд хамрагдсан 55 байгууллагаас судалгаа авч өнгөрсөн онтой харьцуулж үзэхэд 2023 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сарын хооронд дотоодын жуулчны тоо 74,466 байсан бол 2024 оны 01 сараас 04 сарын хүртэл дотоодын жуулчны тоо 108,967 болж 32%, гадаадын жуулчны тоо 12,079 байснаас 15,237 болон 21%-ийн өсөлт үзүүлсэн байна. Мөн орны хүчин чадал 18-20 хувийн өсөлттэй байна.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.06.19, А/284 Гэрээ: 2024.06.20, 24/191"	406,000,000.00	2024.06.27 284,200,000.00	2024.12.24 81,200,000.00	365,400,000.00



СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР 70 ЖИЛ



2024.10.01-нд

13:00 цагт

Хүндэтгэлийн
хурал

18:00 цагт

Хүндэтгэлийн
хүлээн авалт



The Corporate Hotel and Convention Centre

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

Аялал жуулчлалын салбарын нэгдсэн форум (Аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ой)

Монгол Улсад “Аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ой”-г тохиолдуулан салбарын үе үеийн 800 орчим төлөөлөгчдийг оролцуулсан “Аялал жуулчлалын салбарын нэгдсэн форум”-ыг зохион байгуулсан. Тус форумгаар аялал жуулчлалын өнөөгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, салбарын бодлого, төлөвлөлтийг үндэсний хэмжээнд сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулав.

Тус үйл ажиллагаанд ССАЖЗ-ын сайд Ч.Номин, төрийн захиргаа удирдлагын газрын дарга Ч.Энх-Амгалан, ССАЖЗЯамны зөвлөх Ким, АЖМХолбооны ерөнхийлөгч Ц.Баатарсайхан, удирдах зөвлөлийн дарга Б.Золбадрал зэрэг хүндэт зочид оролцсон. Сайд Ч.Номин “Аялал жуулчлалын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг” зэрэг шагналуудыг салбарын онцгойлох ажилчдадаа гардууллаа.

Энэхүү үйл ажиллагааг дэмжиж “Жуулчин” ХХК-иас 8 сая төгрөгийн хандив өгөв.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: 2024.11.14, А/144 Гэрээ: 2024.06.20, 24/291"	100,000,000.00	2024.12.03 70,000,000.00	2024.12.06 30,000,000.00	100,000,000.00

 **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД



• HAPPY •

New Year

2024

GO MONGOLIA
**TOURISM
AWARDS**



MONGOLIA
ALWAYS MOVING

Материал хүлээн авч дуусах хугацаа:

2024 **12 | 20** 18:00

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

Шагнал гардуулах ёслол:

2024 **12 | 27** 18:00

Crocus event hall

“Туризм Авардс” салбарын шилдэгүүдийг тодруулах ёслолын ажиллагаа, нэгдсэн шинэ жил

Аялал жуулчлалын салбарын 2024 оны шилдгүүдийг тодруулах “Go Mongolia tourism awards 2024” арга хэмжээг 12 дугаар сарын 27-ны өдөр Крокус Эвент Холлд зохион байгуулав. Нийт 300 хүний хүлээн авалт хийсэн 5 номинац, 12 оны шилдэг байгууллагуудыг тодруулав.



MONGOLIA
ALWAYS MOVING



БҮРГЭДИЙН БАЯР 2024

2024.03.09~03.10

Чингис Хааны Хурал Цогцолборт



Ерөнхий зохион байгуулагч:



Монгол Улсын
Хурал Цогцолборт



Монгол Улсын
Хурал Цогцолборт



Монгол Улсын
Хурал Цогцолборт



Монгол Улсын
Хурал Цогцолборт

Хамтран зохион байгуулагч:



TICKET 1800 **1800**

7510 1727, 9910 1727, 9595 1727



Монгол Улсын
Хурал Цогцолборт



Монгол Улсын
Хурал Цогцолборт

Бүргэдийн баяр 2024

Бүргэдээр ан хийх уламжлал нь Төв Азийн нүүдэлчдийн дунд ойролцоогоор 6000 жилийн өмнө үүссэн гэж үздэг бөгөөд энэхүү өв соёлыг өнөөг хүртэл хамгийн сайн хадгалан үлдсэн орон бол Монгол Улс юм. Уламжлалт зан үйл болох бүргэдээр ан хийх соёлыг 2010 онд ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвд албан ёсоор бүртгэсэн байдаг.

Өвлийн аялал жуулчлалыг дэмжих, Казахын ард түмний бүргэдээр ан хийх уламжлал, өвөрмөц ёс заншил, амьдралын хэв маягийг дотоод, гадаадын аялагчдад сурталчлан таниулах зорилгоор “Бүргэдийн баяр” эвент арга хэмжээг 2000 оноос хойш Улаанбаатар хотноо уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд энэ жил 17 дахь удаагаа амжилттай болж өндөрлөсөн.

Энэхүү арга хэмжээ нь уламжлалт соёлыг дотоодын аялагчдад сурталчлах, хадгалан үлдээх, аялал жуулчлалын өвөрмөц бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулах зорилготой байв. Үүний хүрээнд 2024 оны 3 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд “Бүргэдийн баяр 2024” арга хэмжээг “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт амжилттай зохион байгуулсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
"Тушаал: Гэрээ:	10,000,000.00		2024.12.26 10,000,000.00	10,000,000.00

БНХАУ-д болсон UTE олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

UTE үзэсгэлэнд анх удаа зохион байгуулалттай 12 туроператор компани Монгол Улсыг төлөөлөн оролцсон нь БНХАУ-ын аялал жуулчлалын зах зээлд, хятадаас гадагшаа жуулчин явуулдаг компаниудад Монгол Улсыг таниулах чухал арга хэмжээ боллоо. Шанхай хотын зах зээлд Монгол Улсын талаар мэдээлэл бараг байхгүй, Монгол Улсыг мэддэггүй байдал нэлээн их байсныг уг үзэсгэлэнд оролцсоноор нэлээн сайн өөрчилж Монгол Улсаа таниуллаа.

Монгол Улсын тухай болон аялал жуулчлал хийх боломжийг таниулах ажлууд их хийгдэж компани бүр тайлбар танилцуулгыг тасралтгүй явууллаа.

Монгол улсаас оролцсон компани бүр БНХАУ-ын аялал жуулчлалын хэдэн зуун компаний төлөөлөл захирал, менежер нартай WeChat сүлжээнд найз бололцож тэднээс мэдээлэл авах, мөн өөрсдийн аялал жуулчлалын мэдээллийг өгч байх сувагтай болж авсан.

БНХАУ-ын аялал жуулчлалын зах зэлд зориулсан 3 маршрут бүтээгдэхүүний танилцуулгыг 10000 хувь хэвлэсэн брошураар тарааж түгээсэн.

Монгол улсаас үзэсгэлэнд оролцсон компани бүр хамтран ажиллах санал олон олноор хүлээж авсан.

ТНБД-ын тушаал гэрээний дугаар	АЖМХ гэрээ хийсэн дүн	АЖМХ-нд олгосон 70%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон 30%-ийн санхүүжилт /төгрөгөөр/	АЖМХ-нд олгосон нийт санхүүжилт
Тушаал: 2024.06.03, А/246	90,000,000.00	2024.06.19 45,000,000.00	2024.12.19 45,000,000.00	90,000,000.00

Хил орчмын аялал жуулчлалыг зохицуулах журам, маршрутыг батлуулж, хэрэгжилтийг хангах

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 142 дугаар тогтоолоор баталсан “Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам”-ыг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан. Тус журам нь Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 142 дугаар тогтоолоор батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах зорилгоор ХХЕГ-тай хамтран хил орчмын аялал жуулчлал эрхлэх хүсэлтэй тур операторуудын төлөөлөлтэй 2024 оны 05 дугаар 19-ны өдөр хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан. ОХУ, БНХАУ-ын хил дагуу 38 маршрутыг боловсруулан Засгийн газраар батлуулсан.

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хорооны 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн IV хурлын шийдвэрээр ССАЖЗЯ-ны дэргэд өвлийн аялал жуулчлалыг идэвхжүүлэх ажлын хэсэг байгуулсан бөгөөд “Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө” боловсруулсан. Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулахаар ажиллаж байна. Дараах санаалчилгуудыг гарган судалж байна.

- 5-6 бүсийг сонгон авч 11 дүгээр сараас эхлэн 2 дугаар сарыг дуустал хугацаанд мөсөн хотхоныг байгуулж, байнгын хэлбэрээр ажиллуулах (Улаанбаатар, Дархан, Мөрөн, Тэрэлж, Улаангом, Дорнод г.м.)
- Уламжлалт томоохон эвентүүдийг өвлийн улиралд зохион байгуулах (Playtime Winter г.м.)
- Цагаан сараар Монголд эвент, аяллын хөтөлбөр гаргах (1 сарын 29 өдөр)
- Шинэ жилээр Монгол эвент, аяллын хөтөлбөр гаргах
- Уламжлалт эвентүүдийг 11-12 сард зохион байгуулах
- Өвлийн авто аялал зохион байгуулах
- БНХАУ-с авто томоохон аяллууд хүлээн авах
- Олимпын эрхтэй тэмцээнүүдийн эрхийг авах, зохион байгуулагч мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх
- Нүүдэлчин өвлийн фестивалийг 2 дугаар сард зохион байгуулах
- Шашны аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн эвентүүд зохион байгуулах
- Бөө мөргөлийн үйл ажиллааны төвүүдийг дэмжих
- Одон орон судлалын үзэгдлүүдийг тохиолдуулан эвент хийх
- E спортын тэмцээн Монгол зохион байгуулах
- Mongolian Night зохион байгуулах (инфлюсерүүд, жуулчны компаниуд, тээврийн компаниуд)

Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах

“Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө” боловсруулж, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор батлуулсан. Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт шинээр байгуулсан “Их хуралдай” цогцолборын нээлтэд оролцов.

Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэсэн өндөр зэрэглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг шинэчлэн батлуулах ажлын хэсэгт АЖМХ-ны хуульч Р.Лхагвабаяр жуулчны баазуудын санал хүсэлтийг нэгтгэн төлөөлөн ажиллалаа.

“Малчин кемп” төсөл

Архангай аймгийн эртний нүүдэлчдийн өлгий аялал жуулчлалын холбоо нь жуулчдыг байрлуулах, нүүдэлчин ахуй соёлыг таниулах, тэдэнд үйлчлэх зорилготой 30 байршилд 60 малчин өрхийг бэлтгэх хоёр үе шаттай сургалтыг зохион байгуулж, сошиал орчинд сурталчлах мэргэжлийн фото зургуудыг 25 “Малчин кемп”-үүдэд авсан. Төсөлд оролцогч малчин өрхүүдийн гэрийг тохижуулахад 179 сая төгрөг зарцуулсан.

“Хөдөлмөр зуслан” хөтөлбөр

Архангай аймгийн эртний нүүдэлчдийн өлгий аялал жуулчлалын холбоо нь сурагчдад малчдын амьдрал, ахуйг танилцуулах 6 өдрийн хөтөлбөрт 9-10 дугаар ангийн 35 сурагч, 5 багш хамрагдсан. Хөтөлбөрт оролцогчдыг Ихтамир сумын таван “Малчин кемп”-т байрлуулсан.

Төв аймгийн аялал жуулчлалын салбар холбоо нь 2024 оны 08 дугаар сарын 18-ны өдөр “Хонины найр” хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд гадаад, дотоодын 100 орчим хүн оролцсон бөгөөд уламжлалт аргаар эсгий хийх, сүү, цагаан идээ боловсруулах, шагайгаар наадах зэрэг уламжлалт ахуй амьдралыг харуулсан.

“Аялал жуулчлалын хөгжилд нутгийн иргэдийн оролцоо” зөвлөгөөн

Аялал жуулчлалын салбарт улсын болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг танилцуулах, орон нутгийн байршуулах хэрэгсэл зочид буудал, жуулчны бааз, дэн буудал, гэр буудал, малчин өрхийн хувьд жуулчдад зориулан стандартын шаардлага хангасан, орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр үндэсний хоол, сэрүүн ундаа хэрхэн хийхийг заан сургах, зочлох үйлчилгээг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах зорилготой тус арга хэмжээг дөрвөн аймаг (Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ, Завхан)-т зохион байгуулсан.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 3

Журам, стандартуудыг сайжруулж,
олон улсын жишигт нийцүүлэх,
хууль эрх зүйн орчныг сайжруулах

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.45-д “Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ.”; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.4-д “аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.”; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-д “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.”; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.5-д “зочид буудал, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох”; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.16-д “аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх”, 5.10-д “хөтчийн ангилал, зэрэглэлийг бий болгож, эрх олгох, гэрчилгээжүүлэх, үйлчилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалтуудыг хийх” гэж заасныг тус тус үндэслэн

Зорилт 1. Салбарын үйл ажиллагааг зохицуулах журмуудыг шинээр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.45-д “Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ.”; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.4-д “аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.”; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-д “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.”; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.5-д “зочид буудал, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох”; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын .4.16-д “аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх”, 5.10-д “хөтчийн ангилал, зэрэглэлийг бий болгож, эрх олгох, гэрчилгээжүүлэх, үйлчилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалтуудыг хийх” гэж заасныг тус тус үндэслэн

Журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах

Хууль, эрх зүйн чиг үүргийн хорооны гишүүд болон гэрээт хуулийн зөвлөх дараах журмын төслийг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан болно. Үүнд:

1. Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам /Тус журам Засгийн газрын 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн 142 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан/;
2. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам /тус журам нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/-ын 2024 оны 01-р сарын 12-ны өдрийн А/18 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан/.
3. Аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох журмын төсөл

Журмын төсөлд санал өгөх

Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-наас томилсон ажлын хэсгийн боловсруулж, батлуулсан дараах журмын төслүүдийн хэлэлцүүлэгт оролцож, саналууд өгсөн. Үүнд:

1. Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам;
2. Өндөр уулын бүсэд авиралт хийх журам.

Батлагдсан журмыг хэрэгжүүлэх

Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмын дагуу Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох комиссыг томилов. Тус комисс нь шалгалтыг зохион байгуулж, шалгалтын болзолыг хангасан 44 хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгов. Оролцогчдоос шалгалтын хураамж 150,000 төгрөг, үнэмлэхний хураамж 20,000 төгрөг хураан авч зарцуулсан ба 2,178,000 төгрөгийг АЖМХ-оос санхүүжүүлэв.

Зорилт 2. Салбарын стандартуудыг шинэчлэн боловсруулах, батлуулах

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу шинээр стандарт боловсруулах

Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран дараах журмын шинэ төслийг тус тус боловсруулсан. Үүнд:

1. Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт;
2. Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандарт;
3. Зочны гэрийн үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт.

Мөрдөгдөж буй стандартыг шинэчлэн боловсруулах

Хууль, эрх зүйн чиг үүргийн хорооны гишүүд болон гэрээт хуулийн зөвлөх дараах стандартуудыг шинэчлэх төслийг боловсруулсан бөгөөд батлуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага – MNS 4934:2002;
2. Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага - MNS 5824:2007;
3. Дэн буудал. Ерөнхий шаардлага – MNS 5738:2007;
4. Чөлөөт цаг.Аялал жуулчлал, байршуулах хэрэгслийн үндсэн нэр томьёо – MNS5407:2004;
5. Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5234:2003;
6. Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4934:2002;
7. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц.Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426:2013.

Ажил мэргэжлийн стандарт боловсруулж батлуулах

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны дэргэдэх Ажил мэргэжлийн стандарт, ур чадварын хөгжлийн төв болон Ти Ви И Ти (TVET) ХХК-тай хамтран аялал жуулчлалын салбарт анх удаа “Жуулчны хөтөч тайлбарлагч” мэргэжлийн “Ажил мэргэжлийн стандарт”-ыг боловсруулж дуусгасан бөгөөд одоогийн байдлаар “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл”-өөр хэлэлцүүлж, батлуулах сүүлийн үе шатандаа явж байна.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу шинээр стандарт боловсруулах

Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран дараах журмын шинэ төслийг тус тус боловсруулсан. Үүнд:

1. Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт;
2. Аялал жуулчлалын цогцолборын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандарт;
3. Зочны гэрийн үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт.

Мөрдөгдөж буй стандартыг шинэчлэн боловсруулах

Хууль, эрх зүйн чиг үүргийн хорооны гишүүд болон гэрээт хуулийн зөвлөх дараах стандартуудыг шинэчлэх төслийг боловсруулсан бөгөөд батлуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага – MNS 4934:2002;
2. Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага - MNS 5824:2007;
3. Дэн буудал. Ерөнхий шаардлага – MNS 5738:2007;
4. Чөлөөт цаг.Аялал жуулчлал, байршуулах хэрэгслийн үндсэн нэр томьёо – MNS5407:2004;
5. Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5234:2003;
6. Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4934:2002;
7. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц.Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426:2013.

Ажил мэргэжлийн стандарт боловсруулж батлуулах

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны дэргэдэх Ажил мэргэжлийн стандарт, ур чадварын хөгжлийн төв болон Ти Ви И Ти (TVET) ХХК-тай хамтран аялал жуулчлалын салбарт анх удаа “Жуулчны хөтөч тайлбарлагч” мэргэжлийн “Ажил мэргэжлийн стандарт”-ыг боловсруулж дуусгасан бөгөөд одоогийн байдлаар “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл”-өөр хэлэлцүүлж, батлуулах сүүлийн үе шатандаа явж байна.

Зорилт 3. Хууль эрх зүйн орчныг сайжруулах

Хуулийг шинэчлэн найруулахад санал өгөх

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг шинэчлэн батлуулах ажлын хэсэгт АЖМХ-ны хуульч ажиллаж байна. Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо нь тус хуулийн шинэчилсэн найруулгад бичгээр саналуудаа хүргүүлсэн.

Засгийн газар болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны хуралдаанд оруулах бодлогын болон зохицуулалтын баримт бичгийн төслийг боловсруулж,

Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран Засгийн газар, АЖХҮХ-ны дараах тогтоол, шийдвэр гаргах үндэслэл, төслийг боловсруулсан. Үүнд:

1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 458 дугаар тогтоол;
2. 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоол;
3. Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тогтоол;
4. Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 239 дүгээр тогтоол;
5. Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 189 дүгээр тогтоол;
6. Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх арга хэмжээний тухай АЖХҮндэсний хорооны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 24/03 дугаар тогтоол.

Стратеги төлөвлөгөөний зорилго 4 Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:

Шинэ сэргэлтийн бодлогын 1.3-д “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.”; Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 4.1-д “Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг түлхүү хийнэ. Мөн агаарын тээврийг либералчлан, нислэгийн тоог өсгөж, жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасныг

Агаарын тээврийн нислэг, суудлын тоог нэмэгдүүлэх

Чингис Хаан олон улсын нисэх буудлыг удирддаг "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт"-ийн идэвх санаачилга, яриа хэлэлцээрийн үр дүнд гадаадын авиакомпаниуд Монгол Улс руу нислэг үйлдэхээр болоод байна. 2024 оны 11 дүгээр сараас БНХАУ-ын Junegao Airlines компани нь Хайнан-УБ чиглэлд, Вьетнам улсын Vietjet Air компани нь Вьетнам улсын хоёр хотоос УБ-ын чиглэлд, 2025 оны зунаас БНХАУ-ын Spring Airlines компани нь Шанхай-УБ чиглэлд, Hainan Airlines компани нь Бээжин-УБ чиглэлд, АНУ-ын United Airlines компани нь АНУ-Токио-УБ чиглэлд тус тус нислэг үйлдэж эхэлнэ. 2024 оны зуны улирлын хуваарьт нислэгийг 2019 оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар, 2023 оны мөн үетэй харьцуулахад 46,4 хувиар өссөн. 2024-2025 оны олон улсын өвлийн улирлын цагийн хуваарьт нийт 13 агаарын тээвэрлэгчийн 4,866 нислэг үйлдэх хүсэлт ирсэн байна. 2023-2024 оны олон улсын өвлийн хуваарьт 13 агаарын тээвэрлэгч 19 чиглэлд нислэг үйлдсэн бол 2024-2025 оны олон улсын өвлийн хуваарьт 13 агаарын тээвэрлэгч 23 чиглэлд нислэг үйлдэхээр төлөвлөгдөж байна.

Жуулчид ихээр нэвтэрдэг боомтуудын ажиллах цаг, нэвтрэх чадамжийг нэмэгдүүлэх

Засгийн газрын 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд өвлийн аялал жуулчлалыг уртасгах, улирлын хамаарлыг бууруулахад боомтуудын ажиллах цаг, нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатайг ССАЖЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад уламжлан хүргүүлсэн.

Орон нутгийн нисэх буудлын зурвасыг сайжруулах

Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай уулзалт хийж орон нутгийн нисэх онгоцны буудлын нисэх, буух зурвасыг засах, маршрутын дагуух замын арчилгаа, засварын талаар мэдээлэл хүргэж ажилласан.

Зорилт 2. Дэд бүтцийг хөгжүүлэх

Аялал жуулчлалын гол чиглэл дагуу ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах

Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хороогоор тогтоол гаргуулж, 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлээс зам дагуух аж ахуйн нэгж, байгуулагуудад олгох ажил эхэлсэн. БОАЖЯ-аас байгаль, түүх, соёлын өв бүхий жуулчдын зорин очих газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах газрын байршлыг орон нутгаас нь санал авч тодорхойлсон. Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд 9 байршилд отоглох цэг байгуулахаар төлөвлөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/168 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан, худалдан авах ажиллагааг зарласан.

Стратеги төлөвлөгөөний зорилго 5

Аялал жуулалчлын салбарын сургалт, судалгааг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэх

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.10-д “Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.”, 2.5.11-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.” 3.4.9-д “Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.”; Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.6-д “Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог ажлын байрны сургалтыг нэвтрүүлнэ.”, 2.2.3.4-д “Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, ... мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2,000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ.”; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.4.1-д “аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн эрэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх”, 4.4.2-д “хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах”, 4.4.3-д “аялал жуулчлалын салбарын хөтөч-тайлбарлагч болон зочлох үйлчилгээний сургагч багш, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хамруулах”; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.5.2-д “дээд боловсролын болон техник мэргэжлийн ажилчдын аялал жуулчлалын мэргэжлийн индексийг шинэчлэх”, 4.5.5-д “аялал жуулчлалын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж, аялал жуулчлалын сургалт, судалгаа, үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлэх”, 4.5.6-д “ажлын байрны стандартад нийцсэн аялал жуулчлалын үйлчилгээний ажилтны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулах”, 4.5.7-д “аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах”, Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын 2-д “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн индексийг нэвтрүүлэх, сургалтын хөтөлбөрийн чадамжийн санг бүрдүүлж, сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх”, 5-д “Хосмог сургалт, ажлын байран дахь сургалтад ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын дагуу иргэд, суралцагчийг хамруулж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх”, 10-д “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, салбар дундын дадлагын баазыг байгуулж хөгжүүлэх” гэж тус тус заасныг

Зорилт 1. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих

Монголын аялал жуулчлалын салбарын стратегийн төлөвлөгөө боловсруулах

Монголын аялал жуулчлалын салбарын стратегийн төлөвлөгөө боловсруулах ажлыг АНУ-ын “Бостон Консалтинг групп”-ээр гүйцэтгүүлэхээр хамтран ажиллах гурван талт гэрээг байгуулсан. Гэрээнд “Бостон Косалтинг групп”, ССАЖЗЯ, АЖМХ гарын үсэг зурсан. Стратегийн төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд “Бостон Консалтинг групп”-ийг шаардлагатай статистикийн мэдээллээр хангаж ажиллав.

Салбар холбоодын судалгааны ажлыг дэмжих

Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо нь дараах 3 төрлийн судалгааг хийсэн. Үүнд:

- “Жуулчны баазуудын хөгжлийн асуудалд 2023” судалгааг 42 жуулчны баазуудыг хамруулж хийсэн;
- Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн байгууллагуудын ерөнхий судалгааг хийсэн;
- “Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдал”-ийн судалгааг 58 жуулчны баазуудыг хамруулж хийсэн.

Аялал жуулчлалын салбарын эрдэм шинжилгээний хурал

“Аялал жуулчлалын судалгаа-2024” эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Чингис хаан музейд зохион байгуулав. Тус эрдэм шинжилгээний хуралд Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүд, аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, судалгаа байгууллагууд болон Төрийн бус байгууллагууд зэрэг нийт 24 байгууллагын 49 судлаачид илтгэлээ хэлэлцүүлсэн. Эрдэм шинжилгээний хурлаар аялал жуулчлалын салбарын хэмжээнд хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг олон нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх, судалгааны нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, аялал жуулчлал судлалыг хөгжүүлэх зорилготой байв. Тус эрдэм шинжилгээний хурлын судалгааны ажлууд нь олон улсын ISSN:2791-1527 дугаартай мэргэжлийн түвшинд хянагддаг “Аялал жуулчлал судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдэнэ.

Зорилт 2. Салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтууд зохион байгуулах

“Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний инновац, төгөлдөршил” сэдэвт сургалт

Монголын аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын оролцогч талууд, багш судлаачдын мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын туршлага хуримтлуулах, орчин үеийн инновацын шилдэг шийдлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зочин багшийг урьж лекц уншуулсан. Тус сургалтыг дараах судлаач багш нар хамтран явуулсан.

1. Professor Kaye chon - Dean and Chair Professor, Walter & Wendy Kwok Family Foundation Professor in International Hospitality Management, School of Hotel and Tourism Management, The Hong Kong Polytechnic University

2. Профессор Д.Гансүх – Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгийн эрдмийн зөвлөлийн дарга, доктор

3. Д.Батболд – Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал

Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт

“Эксперт Хоспиталити” ХХК нь аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилготой олон улсын эксперт багштай сургалтыг дөрвөн өдрийн турш зохион байгуулсан. Сургалтыг зочид буудал, рестораны үйлчилгээ гэсэн хоёр төрлөөр зохион байгуулсан бөгөөд нийт 26 байгууллагын 140 орчим ажилтан хамрагдсаны 96 хувь нь удирдах түвшний ажилтнууд байсан. Сургалтыг удирдан явуулсан проф Kyu Sun, проф Kang Lee Mi Young нарын сургалтын агуулга, заах арга барил нь оролцогчдын сэтгэлд хүрсэн бөгөөд сэтгэл ханамжийн үнэлгээ маш өндөр хувьтай гарсан. Сургалтын үед болон сургалтын дараа оролцогчдын хүсэлтээр тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар чухал зөвлөгөө өгч байсан нь оролцогчдыг улам бүр идэвхжүүлж байсан. Оролцогчдын зүгээс цаашид энэ төрлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж, сургалтын хугацааг уртасгаж өгөх талаар саналаа ирүүлсэн.

Тогооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт

Архангай аймгийн эртний нүүдэлчдийн өлгий аялал жуулчлалын холбоо нь тус сургалтыг аймагтаа зохион байгуулсан. “Монголын ахлах тогоочийн академи”-ийн сургагч багш, мастер тогооч Ю.Базармаа, Ж.Бүүвэйбаатар нар 10 жуулчны баазын 13 тогоочид сургалт явуулж, үндэсний болон европын 47 нэр төрлийн хоолны жорыг заасан.

Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь гурван долоо хоногийн хугацаатай жуулчны хөтөч тайлбарлагчийн ур чадвар олгох “Чадамжийн гэрчилгээ”-тэй сургалтыг нийт гурван удаа зохион байгуулсан. Тус сургалт нь танхимын 14, дадлагын 4 өдрөөс бүрдэх бөгөөд суралцагчид таван төрлийн шалгалтыг хоёр өдөр өгсөн. Суралцагч нь бичиг (онол)-ийн шалгалт, музей тайлбарлах, явган аяллын, автобустай аяллын, илтгэл тавих гэсэн 5 төрлийн шалгалт өгч төгссөн. Сургалтад бүртгүүлэгчдээс ярилцлагын шалгалт авч элсүүлсэн.

I ээлж: 2024.01.08-2024.01.28; Суралцагч: 25; Төгсөгч: 15.

II ээлж: 2024.02.26-2024.03.17; Суралцагч: 32; Төгсөгч: 17.

III ээлж: 2024.04.01-2024.04.21; Суралцагч: 57; Төгсөгч: 25.

“Жуулчны хөтчийн мэдэж байвал зохих цэцэг, ургамал” сэдэвт сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь Монгол орны газар зүйн бүс бүслүүр, ургамалжилтын онцлог, Горхи Тэрэлж, Богд уулын орчим түгээмэл ургадаг цэцэг болон модлог ургамлыг хөтөч тайлбарлагчдад таниулах зорилготой 3 цагийн сургалтад 24 суралцагч хамрагдсан.

“Буддын шашны суурь ойлголт, шүтээн урлал, Гандантэгчэнлин хийдийн тухай” сэдэвт сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь Буддын шашны тухай суурь ойлголтууд, Монголын сүм хийдийн архитектурын онцлог, бэлгэдэл, шүтээн урлал, бурхдын дүрүүд, Гандантэгчэнлин хийдийн түүх, сүм хийдийн зарим ёслол гэх мэт буддын шашны талаар хөтөч тайлбарлагчдад мэдлэг олгох сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд 120 мянган төгрөгийн төлбөртэй 3 өдрийн сургалтад 68 хөтөч тайлбарлагч хамрагдсан.

“Монголын геологи ба байгалийн өвөрмөц тогтоц” сэдэвт сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь Монголын геологийн талаарх товч ойлголт, монгол орны гадаргын морфологи, өвөрмөц тогтоцтой газар, гарал үүслийн талаар хөтөч тайлбарлагчдад мэдлэг олгох сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан бөгөөд 45 мянган төгрөгийн төлбөртэй 3 цагийн сургалтад 38 хөтөч тайлбарлагч хамрагдсан.

“Монгол орноос олдсон үлэг гүрвэлүүд” сэдэвт сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь Монголын палеонтологи, үүсэл хөгжил, үлэг гүрвэлийн тухай, судалгааны түүх, сүүлийн үед хийгдэж буй судалгаа, томоохон нээлтүүд, Монгол орноос олдсон голлох олдворуудын талаар хөтөч тайлбарлагчдад мэдлэг олгох сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан бөгөөд 45 мянган төгрөгийн төлбөртэй 3 цагийн сургалтад 28 хөтөч тайлбарлагч хамрагдсан.

“Монголын Үндэсний музейг англи хэлээр тайлбарлах” сэдэвт сургалт

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь Монгол нутаг дахь эртний төрт улсууд, үндэсний хувцас, гоёл чимэглэл, уламжлалт соёл, ахуй, социалист болон ардчилсан Монгол улсын талаар хөтөч тайлбарлагчдад мэдлэг олгох 50-60 мянган төгрөгийн төлбөртэй 5 цагийн сургалтыг гурван удаа зохион байгуулсан.

I ээлж: 2024.01.31; Суралцагч: 30.

II ээлж: 2024.02.18; Суралцагч: 23.

III ээлж: 2024.03.28; Суралцагч: 21.

“Монголын Үндэсний музейг солонгос хэлээр тайлбарлах” сэдэвт сургалт

Монгол нутаг дахь эртний төрт улсууд, үндэсний хувцас, гоёл чимэглэл, уламжлалт соёл, ахуй, социалист болон ардчилсан Монгол улсын талаар хөтөч тайлбарлагчдад мэдлэг олгох 60 мянган төгрөгийн төлбөртэй 5 цагийн сургалтыг хоёр удаа зохион байгуулсан.

I ээлж: 2024.03.24; Суралцагч: 30.

II ээлж: 2024.04.27; Суралцагч: 30.

“Social Media” сургалт

Гишүүн байгууллагуудын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлахад сошиал медиаг хэрхэн ашиглах талаар чадвар олгох зорилготой тус сургалтад 13 байгууллага хамрагдсан.

“Start-Up” сургалт

Аялал жуулчлалын салбарт шинээр үйл ажиллагаа явуулахаар ажиллаж буй START UP компаниудад хууль эрх зүй, сошиал маркетинг, хүний нөөцийн менежмент гэсэн агуулгаар сургалт зохион байгуулагдсан. Сургалтад гишүүнээр элссэн 6 байгууллага хамрагдснаас 4 тур оператор, 2 жуулчны бааз оролцсон.

“Soft Skills” сургалт

МҮХАҮТ-ийн Бизнес Академитай хамтран “Harvard ManageMentor” хөтөлбөрийн “Intro” түвшний зөөлөн ур чадварын 4 цагийн сургалтыг гишүүн байгууллагын оролцогчдод 150 мянга, гишүүн бус байгууллагын оролцогчдод 200 мянган төгрөгийн төлбөртэйгээр 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 37 оролцогчтойгоор зохион байгуулсан.

Аялал жуулчлалын менежментийн сургалт

“Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн Аялал жуулчлалын хөгжлийн төвийн 8 ажилтанд зориулсан “Аялал жуулчлалын менежмент” сэдэвт 8 цагийн сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Сургалт нь аялал жуулчлалын хууль, эрх зүйн орчин, аялал зохион байгуулалт, Монголын аялал жуулчлалын өнөөгийн байдал, салбарын оролцоо зэрэг агуулгыг багтаасан.

Санхүүгийн сургалт

АЖМХ-ны гишүүдэд зориулсан санхүүгийн сургалтыг Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Миг даатгалтай хамтран 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр СЭЗИС-ийн 4 давхарын хурлын зааланд зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 104 оролцогчдод татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголт болон аялал жуулчлалын компаниудад зориулсан даатгалын бүтээгдэхүүний талаар мэдээлэл хүргэж, асуултад хариулав. Даатгалын талаарх сургалт, мэдээллийг 12 сарын 17-ны 15 цагт онлайнаар явуулав.

Зорилт 3. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн сургууль байгуулах ажлыг эхлүүлэх

Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлийн боловсролын сургууль байгуулах менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын 2020 онд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын “Аялал жуулчлалын төрийн өмчит корпорац (Korea Tourism Organization)”-аас Монгол Улсын Засгийн газарт сургалтын зориулалттай барилга, байгууламжийг 2024 оны 12 дугаар сард хүлээлгэн өгөхтэй холбогдон Монголын аялал жуулчлалын салбарын мэргэжлийн боловсролын сургууль байгуулах менежментийн төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээ, шаардлага үүссэн. ССАЖЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/27 тоот тушаалаар менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг энэхүү төлөвлөгөөг 11 үндсэн дэд сэдвийн хүрээнд боловсруулав.

Стратеги төлөвлөгөөний зорилго 6 Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ-ийн тогтвортой үйл ажиллагааг хангах

Зорилт 1. Удирдах зөвлөл, ажлын албаны үйл ажиллагааг жигдрүүлэх

Удирдах зөвлөлийг бүрдүүлэх

Бүх гишүүдийн хурлыг нийт 8 удаа хуралдуулж, 9 бүлэг 44... зүйл бүхий дүрмийг батлуулав. Удирдах зөвлөлийг 29 хүний бүрэлдэхүүнтэй байхаар дүрэмд тусган оруулж батлуулав. Аялал жуулчлалын салбарын оролцогч талуудыг жигд оролцуулах квот бий болгож бүх гишүүдийн хурлаар батлуулсан. Тур оперотор, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз болон байршуулах үйлчилгээ, хүний нөөц, жуулчин тээвэр, жуулчны хөтөч тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч, агаарын тээвэр, адал явдалт аялал жуулчлал эрхлэгч гэсэн 10 төрлийн үйл ажиллагаа эрхлэгч нараас бүрдсэн Удирдах зөвлөлийг сонгон баталгаажуулсан. Дүрмийн өөрчлөлтийг Улаанбаатар хотод бүртгүүлэн баталгаажуулав. Удирдах зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Чиг үүргийн хороодыг бүрдүүлэх

Удирдах зөвлөлийн гишүүд нь гурваас доошгүй чиг үүргийн хороонд харьяалагдаж ажиллах журмыг батлав. АЖМХ нь дараах чиг үүргийн хороодтой байна. Үүнд:

1. Зах зээлийн чиг үүргийн хороо
2. Дэд бүтцийн чиг үүргийн хороо
3. Сургалт, судалгааны чиг үүргийн хороо
4. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, эвентийн чиг үүргийн хороо
5. Маркетинг цахим шилжилтийн чиг үүргийн хороо
6. Хууль эрх зүй, стандартын чиг үүргийн хороо

Ажлын албыг байгуулах

АЖМХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын албыг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах шийдвэрийг гаргаж, зарцуулах төсвийг батлав. Тус ажлын алба нь дараах орон тооны бүтэцтэй ажиллав. Үүнд:

1. Ажлын албаны дарга буюу гүйцэтгэх захирал;
2. Стратеги бодлого төлөвлөлт & Гадаад хамтын ажиллагаа хариуцсан дэд дарга;
3. Ерөнхий нягтлан бодогч;
4. Тооцооны нягтлан бодогч;
5. Хуульч (гэрээт);
6. Маркетингийн менежер;
7. Гадаад харилцааны менежер;
8. Судалгаа, хөгжил хариуцсан менежер;
9. Сургалт хариуцсан менежер;
10. Салбар холбоод хариуцсан менежер;
11. Гишүүнчлэл хариуцсан менежер;
12. Бүртгэл мэдээлэл хариуцсан менежер;
13. Худалдан авалт хариуцсан менежер;
14. График дизайнер;
15. Оффис , архив бичиг хэргийн ажилтан.

Хяналтын зөвлөлийг байгуулах

АЖМХ-ны дүрмийн дагуу 9 хүний бүрэлдэхүүнтэй Хяналтын зөвлөлийг бүх гишүүдийн хурлаас сонгов. Хяналтын зөвлөл нь нийт 2 удаа Ажлын албаны болон Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлтийг Удирдах зөвлөл болон Ажлын албанд хүргүүлсэн. Хяналт шалгалтын талаарх мэдээллийг Бүх нийтийн хурал дээр танилцуулсан.

Зорилт 2. Гишүүдийг бүртгэх ажлыг жигдрүүлэх

Вэб сайт ашиглалтад оруулах

Аялал жуулчлалын салбарын mto.mn мэдээллийн нэгдсэн сайт ашиглалтад оров. Тус вэбсайтаар аялал жуулчлалын салбарт өрнөж буй мэдээ, мэдээлэл болон эвент, тайлан, үйл ажиллагаа, үзэсгэлэн, судалгаа, сургалт, гишүүнчлэлийн мэдээлэл, хууль эрхзүйн мэдээлэл, журам, тогтоол зэрэг бүхий л мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэв.

Аялал жуулчлалын тухай хуулийн дагуу бүртгэл хийх

Аялал жуулчлалын тухай хуулийн дагуу байгууллагууд болон хөтөч тайлбарлагчийг бүртгэх ажлыг гүйцэтгэж байна.

Гишүүнчлэлийн гэрчилгээ

Гишүүнчлэлийн гэрчилгээг одоогоор 400 орчим байгууллагад олгосон бөгөөд гэрчилгээ нь нууцлалын 3 зэрэгтэй, хээ бүхий ялтастай.

Мэдээ, мэдээлэл түгээх

АЖМХ-ны вэбсайт болон бусад сошиал цахим хуудсуудаар салбарын мэдээллийг тогтмол сурталчлан түгээж байна.

**Зорилт 2. Гишүүдийг бүртгэх ажлыг
жигдрүүлэх**

**Зорилт 3. Салбар холбоодын үйл ажиллагааг
дэмжин ажиллах**

А. Бүрэн эрхт салбар холбоод

Америк-Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэгш нийгэмлэг

1. Салбар холбооны дүрэм болон гишүүнчлэлийн журмаа баталж, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны салбар холбоогоор бүртгүүлэв.
 2. Гишүүддээ зориулсан дараах 3 төрлийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:
 - o АНУ-ын аялал жуулчлалын зах зээлийн онцлог, тус зах зээлд хэрхэн амжилттай ажиллах вэ?;
 - o АНУ-ын жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, тур операторын хүний нөөцийг чадавхжуулах;
 - o Тур операторын үйл ажиллагааг хялбаршуулах, таск менежментийн програм хангамж ашиглах, тур менежерийн гүйцэтгэлийг хэмжих.
 3. Хамтын ажиллагаа өргөжүүлэх санаачлагуудыг дараах чиглэлүүдээр эхлүүлэв. Үүнд:
 - o АНУ-ын ЭСЯ, Peace Corps, АНУ дахь Монгол улсын ЭСЯ, USAID
 - o АНУ-ын аялал жуулчлалын зах зээлийн судалгаа
 - o АНУ-ын зах зээлийн цар хүрээ, хэрэглэгчдийн онцлог
 - o АНУ зах зээл дээрх агентуудын мэдээлэл
 - o АНУ-ын үзэсгэлэн, зах зээлд нэвтрэх арга замууд
- АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 11,4 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Архангай аймгийн Эртний нүүдэлчдийн өлгий аялал жуулчлалын холбоо

1. Мэдээллийн төвийн байрыг засварлан ашиглалтад оруулав.
 2. “Малчин кемп” төслийг эхлүүлэв.
 3. “Нэг жуулчин-Нэг ямаа” хөтөлбөрийг эхлүүлэв.
 4. АРА өвлийн фестивалийг хамтран зохион байгуулав.
 5. “Хөдөлмөр зуслан” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.
 6. Вэбсайт, социал платформуудыг ашиглаж эхлэв.
 7. Тогооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулав.
 8. “Аялал жуулчлалын 7 хоног” арга хэмжээнд оролцов.
- АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 9,9 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Европ зах зээлийн салбар холбоо

1. Салбар холбооны дүрмээ баталж, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ажлын алба байгуулах зохион байгуулалтын дотоод ажлуудыг жигдэрүүлэв.

2. Олон улсын “ITB-2024 Berlin” болон “WTM London” үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, нийт 20 гишүүн байгууллагуудаа оролцуулав.

АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 16,2 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо

1. Салбар холбооны засаглал, зохион байгуулалтын асуудлаар бүх гишүүдийн хурлыг хоёр удаа зохион байгуулав.

2. Хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр 10 орчим байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг болон гэрээ байгуулав.

3. Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн чиглэлийн гурван төрлийн судалгаа хийв.

4. Цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд 55 жуулчны баазыг хамруулав.

5. 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлд 14 байгууллагыг хамруулж, 21 тэрбумын төгрөгийн зээл авав.

6. Тусгай хамгаалалттай газар нутаг /ТХГН/-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад санал өгч, жуулчны баазуудын газрын гэрчилгээг сунгуулах асуудлаар БОАЖЯ-тай 10 гаруй удаагийн уулзалт хийв.

7. “Аялал жуулчлалын 7 хоног-Tourism week” арга хэмжээний жуулчны баазуудад зориулсан сургалт болон B2B уулзалтын хэсгүүдийг зохион байгуулсан. Тус арга хэмжээний салбар хуралдаанд гарсан саналуудыг нэгтгэн БОАЖ-ын сайдад хүргүүлсэн.

8. “Улаанбаатар травел экспо 2024” арга хэмжээний үеэр “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулсан.

9. “Нүүдэлчин фестиваль”-д оролцов.

10. Салбарын нэг журам, хоёр стандартыг шинээр болон шинэчлэн найруулах хэлэлцүүлэгүүд зохион байгуулж, саналуудыг БОАЖЯ-д хүргүүлэв.

АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 22,1 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо

1. “Жуулчны хөтөч тайлбарлагчдын III чуулган”-ыг зохион байгуулав.
2. Хөтөч тайлбарлагчдыг гэнэтийн ослын даатгалд даатгуулав.
3. АЖМХ НЭЗХЭ, МХТХ, Аялал Жуулчлалын Багш Судлаачдын Нийгэмлэг нарын хамтарсан ажлын хэсэг “Жуулчны Хөтөч Тайлбарлагч” Ажил мэргэжлийн стандартыг боловсруулж батлуулах бэлтгэл ажлыг хангав.
4. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох журмын дагуу анхны шалгалтыг зохион байгуулав.
5. Найман төрлийн мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтуудыг давтамжтай зохион байгуулж 406 хөтөч тайлбарлагчдыг хамруулав. АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 6,6 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбоо

1. БНСУ-д зохион байгуулагдсан “SITF 2024” Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн болон “Travel show 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох ажлыг зохион байгуулж, гишүүн 23 байгууллагыг оролцуулав.
2. “Хоггүй Тэрэлж” болон “Дээлтэй хөтөч” аянд нэгдэж “Жуулчин төгөл” хөтөлбөрт хамтран оролцов. АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 25,1 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Төв аймгийн аялал жуулчлалын холбоо

1. Салбар холбооны бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, холбооны дүрмээ шинэчлэн батлав.
 2. Хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр 2024 оны 07 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд EATOF (East Asia Inter-Regional Tourism Federation) холбооны 18 дугаар их хурлыг Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан. Тус үйл ажиллагааны үеэр БНСУ-ын Кангвон мужийн Аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Мөн Төв аймгийн сумд болон малчдын бүлгүүдтэй гурван талт гэрээ байгуулав.
 3. “Хонины найр” арга хэмжээг зохион байгуулав.
 4. “Аялал жуулчлалын 7 хоног-Tourism week” арга хэмжээний B2B уулзалтад 14 гишүүн байгууллагуудыг оролцуулж, үйл ажиллагаагаа сурталчлав.
 5. БНХАУ-д зохион байгуулсан “Go Mongolia” рөүдшоунд холбооны 3 гишүүн оролцсон.
 6. Чингис Хаан олон улсын нисэх буудлын “Мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сараас 2024 оны 08 дугаар сар хүртэл хариуцан ажилласан.
 7. Төв аймгийн аялал жуулчлалын өвлийн маршрутыг гарган МАЖХ-ны зохион байгуулсан “Tourism Time” арга хэмжээнд сурталчилсан.
- АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 7,1 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Хятад зах зээлийн салбар холбоо

1. “Go Mongolia” roadshow арга хэмжээг БНХАУ-ын Бээжин болон Гуан жао хотууд, Засаг захиргааны онцгүй бүс Хонгконгт зохион байгуулж, Монголын 17 тур оператор компаниудыг оролцуулав.
 2. COTTM (China Outbound Travel & Tourism Market), CITM (China International Travel Mart) үзэсгэлэнд оролцох ажлыг зохион байгуулж, Фү Зянь фам турд оролцов.
 3. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Дорнод, Дорноговь аймгийн удирдлагуудтай уулзалт хийв.
- АЖМХ-ны дүрмийн дагуу гишүүдийн татварын буцаан олголт болох 27,3 сая төгрөгийг Ажлын албанаас олгов.

Б. Хязгаарлагдмал эрхт салбар холбоод

Адал явдалт тусгай сонирхлын аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам болон Өндөр уулын бүсэд авиралт хийх журмын төслүүдийг боловсруулж, хэлэлцүүлгүүдийг үе шаттай хийсэн. Тус журмууд нь БОАЖ-ын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/18 дугаар тушаал, 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан.
2. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх улирлын хамтарсан бэлтгэл, Уулын морь, мото, рафтинг, авиралт зохион байгуулсан.
3. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үндсэн хөтөч, рафтингийн мэргэшүүлэх сургалт, анхны тусламжийн хөтөлбөр сургалтуудыг тус тус зохион байгуулсан.
4. Экстрим спорт аялалын фестивалийг зохион байгуулсан.

Булган хангай Булган аймгийн аялал жуулчлалын холбоо

“Нэг жуулчинд нэг хонь” хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн 16 сумын малчин өрхүүдэд хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулж нийт 1,552 малчин өрхийг бүртгэсэн.

Монгол Японы аялал жуулчлалын холбоо

1. “Travel Expo Japan- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох ажлыг зохион байгуулж, 10 компанийг оролцуулав.
2. Япон улсад зохион байгуулагдсан “Хаврын баяр-2024” арга хэмжээнд оролцов.
3. Японы аялал жуулчлалын төрийн байгууллагуудтай ирээдүйн хамтын ажиллагааны талаар хийх уулзалтуудыг зохион байгуулсан. ЖАЙКА олон улсын байгууллагатай Монголд хэрэгжүүлж буй аялал жуулчлалын холбогдолтой төслийг үргэлжлүүлэх талаар, Японы Газар Дэд Бүтцийн Яамтай нислэгийн асуудлаар, JNTO байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх чиглэлээр, Нагасаки мужтай ажиллах хүчний сургалт, судалгаа, туршлага солилцох чиглэлээр уулзалтуудыг тус тус хийсэн.
4. Япон улсаас ирэх жуулчны тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд B2B бизнес уулзалт зохион байгуулав. Тус уулзалтад Японы тал 26 хүний бүрэлдэхүүнтэй ирсэн бөгөөд Монголын талын 20 байгууллагатай нүүр тулсан уулзалт хийв.

Зорилт 4. АЖМХ-ны хамтын ажиллагааг хөгжүүлэх

Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах

Гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах төрийн болон олон нийтийн байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Үүнд:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Булган аймгийн Засаг даргын тамгын газар (“Нэг жуулчин-Нэг хонь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талт санамж бичиг)
2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, (“Нэг жуулчин-Нэг ямаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талт санамж бичиг)
3. “Танусофт” ХХК
4. “Монголын Гэрэл Зурагчдын Нэгдсэн Холбоо” ГҮТББ
5. “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим” ТББ
6. “Монголын Чопперчин Ахан Дүүс” НҮТББ, БНХАУ-ын “1,000 майлс клуб” (Гурван талт санамж бичиг)
7. “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компани
8. “Юбикаб” ХХК, “Томё Эдтек” ХХК (Гурван талт санамж бичиг)
9. Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
10. “Хайпэй” ХХК
11. “Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо” ТББ
12. “МИГ Даатгал” ХХК
13. Нью Улаанбаатар Интернейшнл Эйрпорт ХХК (NUBIA)
14. БНСУ-ын Сэжон их сургуулийн “Аялал Жуулчлалын Салбарын Дата Аналитикийн Лаб”

Салбарын болон үндэсний хэмжээний хороо, зөвлөлд ажиллах

“Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 69 дугаар захирамжийн дагуу ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолын төлөөлөл болох гурван гишүүний нэг гишүүнээр Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны гүйцэтгэх захирал сонгогдон ажиллах болсон.

Зорилт 5. Хууль эрх зүйн баримт бичгүүдийг шинээр боловсруулах, батлуулах болон байгууллагын баримт бичгүүдийн нийцлийг бий болгох

АЖМХ-ны дотоод үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмын нийцлийг судлах, журмуудыг шинэчлэх, шаардлагатай журмуудыг шинээр боловсруулж батлуулах

“Эрдэм сургалт, судалгааны хүрээлэн” НҮТББ-г гүйцэтгэгчээр шалгаруулан дараах ажлыг гүйцэтгүүлэв. Үүнд:

1. Байгууллагын дүрэм, журмууд нь холбогадох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актад нийцсэн эсэхийг шалгуулах зорилгоор хууль зүйн дүгнэлт гаргаж, сайжруулах саналыг хүлээн авсан.

Үүнд:

- o Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- o Гишүүн элсүүлэх, бүртгэх журам;
- o Салбар холбооны статусыг зохицуулах журам;
- o Худалдан авах ажиллагааны журам;
- o Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- o Аялал жуулчлалын салбарын ажилтны ёс зүйн дүрэм.

2. Зөвлөх үйлчилгээний байгууллагаас дараах журмын төслүүдийг шинээр боловсруулан ирүүлсэн. Үүнд:

- o Гишүүний татвар, хураамжийн журам;
- o Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам;
- o Тендер шалгаруулалтын журам зэрэг болно.

3. “Эрдэм судалгааны хүрээлэн” НҮТББ-ын судлаачид өөрсдийн боловсруулсан хууль зүйн дүгнэлтэд үндэслэн “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрэмд оруулах зарим нэг нэмэлт, өөрчлөлтүүдийг санал болгосон.

4. Хууль, эрх зүйн чиг үүргийн хороо болон гэрээт хуулийн зөвлөх дараах журмын төслүүдийг боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулсан. Үүнд:

- o Салбарын холбооны статусыг зохицуулах журам;
- o Гишүүн элсүүлэх журам;
- o Худалдан авах ажиллагааны журам;
- o Албан хэрэг хөтлөлтийн журам;
- o Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- o Хөдөлмөрийн дотоод журам зэрэг болно.

АЖМХ-ны дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах, бүх гишүүдийн хурлаар батлуулах, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх

АЖМХ-ны Хууль, эрх зүйн чиг үүргийн хорооноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Бүх гишүүдийн хурлын 2023 оны 12-р сарын 11-ний өдрийн хурлаар батлагдсан дүрэмд дараах агуулгаар нийт 80 орчим нэмэлт, өөрчлөлтийг дараах 7 агуулгын хүрээнд оруулсан. Үүнд:

1. Дүрэмд үг, үсгийн болон агуулгын хувьд засах, өөрчлөх, сайжруулах шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулав;
2. Байгууллагын эрх зүйн статусыг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн өөрчлөх хууль зүйн техникийн болон агуулгын өөрчлөлтүүдийг оруулав;
3. Удирдах зөвлөлийн гишүүдийн эрх, үүргийг тусгаж, Удирдах зөвлөлийн төсөв болон нарийн бичгийн талаарх зохицуулалтыг дүрэмд тодорхой тусгав;
4. Гишүүнчлэлийг өргөжүүлж мэргэжлийн холбоод буюу салбарын төрийн бус байгууллагууд холбооны гишүүнээр элсүүлэх боломжийг бүрдүүлэв;
5. Гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийн нарийвчлан зохицуулав;
6. Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол жуулчин, аялал жуулчлалын байгууллагын хооронд аялал жуулчлалын гэрээтэй холбогдон гарсан маргааныг энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлүүлж болно.” гэж заасны дагуу эвлэрүүлэн зуучлалын талаарх зохицуулалтыг тусгав;
7. Хяналтын зөвлөл нь Удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаа болон холбогдох бусад эрх бүхий албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаанд хяналт хийх боломжийг бүрдүүлж, холбооны үйл ажиллагааны хяналтыг сайжруулав.

Салбарын хууль эрх зүйн актын мэдээллийг АЖМХ-ны цахим хуудаст нээлттэй байршуулах

Аялал жуулчлалын эрх зүйн актын мэдээллийн сан үүсгэх зорилгоор 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах эрх зүйн актуудыг mto.mn цахим хуудасны “Эрх зүйн акт” хэсэгт нээлттэй байршуулв. Үүнд:

1. Аялал жуулчлалын тухай хууль;
2. Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам;
3. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам;
4. Өндөр уулын бүсэд авиралт хийх журам;
5. Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам;
6. Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны ажиллах журам;
7. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрэм;
8. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журам;
9. Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй 12 стандарт зэрэг болно.

АЖМХ-НЫ САЛБАР ХОЛБООДЫН 2024 ОНЫ САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН ЖАГСААЛТ

№	Салбар холбоод	Гишүүдийн тоо	Г/ татварын буцаалтын дүн	Хоорондын тооцоогоор суутгал	Олгосон дүн
1	Хятад зах зээлийн салбар холбоо	69	27,350,000.00	16,800,000.00	10,550,000.00
2	Европ зах зээлийн салбар холбоо	47	16,200,000.00		16,200,000.00
3	Төв аймгийн аялал жуулчлалын холбоо	23	7,100,000.00		7,100,000.00
4	Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо	55	22,150,000.00	2,622,065.00	19,527,935.00
5	"Эртний нүүдэлчдийн өлгий" Архангай аймгийн аялал жуулчлалын холбоо	21	10,250,000.00		10,250,000.00
6	Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн холбоо	22	6,600,000.00		6,600,000.00
7	Америк Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Тэгш Нийгэмлэг	31	11,000,000.00		11,000,000.00
8	Монголын Солонгос зах зээлийн АЖ-н холбоо	45	25,100,000.00		25,100,000.00
	ДҮН	333	125,750,000.00	19,422,065.00	106,327,935.00

ХАНДИВЫН ТАЙЛАН 2024

д/д	Огноо	Хандив өгсөн байгууллагын нэр		Хандив зарцуулсан төсөл
1	2024-01-04	М СИ ЭС ПРОПЕРТИЙЗ ХОЛДИНГ ХХК	250,000,000.00	Мазаалай мөсний наадам
2	2024-01-12	ЖУУЛЧИН ТУРИЗМ КОРПОРАШН ХХК	150,000,000.00	Мазаалай мөсний наадам
3	2024-05-21	АПУ ХК	30,000,000.00	Нас дэйли нөлөөлөгч нарын контент
4	2024-09-30	ЖУУЛЧИН ХХК	8,000,000.00	70 жилийн ойн баярт
		НИЙТ ДҮН	438,000,000.00	

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Гүйцэтгэл: -137,550,456.65

№	Утга	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл
	Орлогын дүн	529,200,000.00	6,368,178,786.99
1	Гишүүдийн татварын орлого	529,200,000.00	401,702,000.00
2	Хөтөлбөр, төслийн орлого		5,379,787,450.50
3	Бэлэг, хандив, тусламжийн орлого		438,000,000.00
4	Бусад орлого		148,671,336.49
	Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал		5,728,874,436.00
			5,728,874,436.00
	Ажлын албаны зардал	834,070,000.00	776,854,807.64
1	Цалингийн зардал	522,000,000.00	423,867,253.59
2	НДШ-н зардал	67,860,000.00	59,687,193.11
3	Засвар үйлчилгээний засвар		1,028,800.00
4	Түрээсийн зардал	86,400,000.00	86,899,200.00
5	Албан томилолтын зардал	54,000,000.00	41,117,775.11
6	Элэгдэлийн зардал		7,329,211.65
7	Шуудан холбооны зардал	42,480,000.00	11,865,329.56
8	Шатахууны зардал		519,217.00
9	Бүх гишүүдийн хурлын зардал		25,372,768.00
10	Хурал уулзалтын зардал		8,385,320.00
11	Бичиг хэргийн зардал	30,240,000.00	8,427,510.00
12	Банкны шимтгэлийн зардал		398,950.00
13	Хангамжийн материалын зардал		676,790.00
14	Мэргэжлийн үйлчилгээний зардал		84,816,466.51
15	Зар сурталчилгааны зардал		9,218,023.11
16	Бусад зардал	31,090,000.00	5,045,000.00
17	Даатгалын зардал		2,200,000.00
	АШИГ АЛДАГДАЛ		-137,550,456.65

"Нийслэлийн аялал жуулчлалын газар"-аас дэмжлэг болгосон төслийн мөнгө		
2024.02.20	50,000,000.00	Мазаалай олон улсын цас мөсний наадам (Геннисийн рекорд тогтоолгох үйл ажиллагаа)
2024.04.17	40,000,000.00	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, ХонгКонг, Гуанжоуд зохион байгуулсан "Go Mongolia" рүүдшоу
2024.04.23	25,220,000.00	

БАЛАНС ПРО АУДИТ ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл, зүтсөрсинг, санхүүгийн зөвөлгөө үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлагналын
олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2025 он

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон таг (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	109,921,152	744,464,081
Дансны авлага	5,280,000	11,091,775
Бараа материал	2,107,654	10,614,253
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	104,984,244	34,300,000
Эргэлтийн хөрөнгийн дүн	222,293,049	800,470,109
Үндсэн хөрөнгө	20,263,700	42,417,500
Хуримтлагдсан элэгдэл	-	7,329,212
Эргэлтийн бүс хөрөнгийн дүн	20,263,700	35,088,288
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	242,556,749	835,558,397
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
Дансны өглөг	6,726,101	693,697,118
Цалингийн өглөг	3,603,264	-
Татварын өр	3,236,577	19,773,826
Богино хугацаат зээл	28,800	15,421,354
Бусад өглөг	-	15,338,503
Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,594,743	744,230,800
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	13,594,743	744,230,800
Хуримтлагдсан үр дүн	228,962,006	91,327,596
Цэвэр хөрөнгийн дүн	228,962,006	91,327,596
Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн	242,556,749	835,558,397

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1.1 Өмнөх үлд 1.2 Зөрүү 1.3 Эхний үлд		
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Гишүүдийн татвар	64,200,000	401,720,000
Хөтөлбөр төслийн орлого	538,613,345	5,379,787,451
Бэлэг хандив, тусламжийн орлого	5,150,000	438,000,000
Бусад орлого	15,800,000	148,671,336
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	623,763,345	6,368,178,787
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Төсөл хэрэгжүүлсэний зардал	317,032,150	5,728,874,436
Ерөнхий ба удирдлагын зардал		
Цалин хөлс, шагнал	36,978,273	423,867,254
Нийгмийн даатгалын шимтгэл	2,530,000	59,687,193
Засвар үйлчилгээний зардал		1,028,800
Түрээсийн зардал	12,880,896	86,899,200
Албан томилолтын зардал		41,117,775
Элэгдлийн зардал		7,329,212
Зар сурталчилгааны зардал	12,251,029	9,218,023
Шуудан, холбооны зардал	183,900	11,865,330
Шатахууны дардал	130,000	519,217
Бусад зардал	12,835,090	135,322,805
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	394,821,338	6,505,729,244
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	228,942,006	(137,550,457)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал		
Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал)	-	-
Татварын зардал	541,238	83,954
Бусад		
Тайлант үеийн цэвэр үр дүн	228,400,768	(137,634,410)

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	228,962,006	228,962,006
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(137,634,410)	(137,634,410)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	91,327,596	91,327,596

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1.1 Өмнөх үлд 1.2 Зөрүү 1.3 Эхний үлд		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	623,763,345	6,892,456,308
(а) Гишүүдийн татвараас орсон мөнгө	64,200,000	409,220,000
(б) Төсөл, хөтөлбөрөөс орсон мөнгө	538,613,345	5,895,911,125
(в) Бэлэг, хандив, тусламж	5,150,000	52,050,000
(г) Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө	15,800,000	
(д) Бусад		535,275,183
Мөнгөн зарлагын дүн (-)	513,842,193	6,236,599,113
(а) Ажиллагчдад төлсөн мөнгө	29,984,770	329,121,756
(б) Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,828,800	95,812,899
(в) Бараа материал худалдан авахад төлсөн	466,017,727	8,046,599
(г) Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	12,880,896	99,304,615
(д) Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	130,000	519,217
(е) Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө		5,681,197,230
(ё) Хүүний төлбөрт төлсөн мөнгө		
(ж) Татварын байгууллагад төлсөн мөнгө		20,396,798
(з) Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		2,200,000
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	109,921,152	655,857,194
2. Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө		(22,153,800)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(22,153,800)
б. Хүү ба урамшууллын орлого		839,536
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	839,536
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	109,921,152	634,542,930
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэг	-	109,921,152
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэг	109,921,152	744,464,081



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

ХЯНАСАН:
АЖЛЫН АЛБАНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.НАРАНГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕР
ГРАФИК ДИЗАЙНЕР

Т.ЗУЛАА
О.ГАНЧИМЭГ